

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр, Лхагва гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-14

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 15-40

---

1.Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2026.04.20-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, үргэлжилнэ/	15-23
2.Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	23-25
3.Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	25-40

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны  
06 дугаар сарын 03-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 45 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Батсүмбэрэл, Д.Бут-Очир, Г.Хосбаяр, Ө.Шижир, С.Эрдэнэболд;

Чөлөөтэй: О.Амгаланбаатар, Э.Бат-Амгалан, Л.Гантөмөр, Х.Жангабыл, Л.Оюун-Эрдэнэ, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: Б.Батбаатар.

**Нэг.Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2026.04.20-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, үргэлжилнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гадаад харилцааны дэд сайд Г.Амартүвшин, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Д.Бат-Өлзий, Хууль зүй, дотоод хэргийн яамны Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтсийн дарга А.Энх-Эрдэнэ, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл, мэргэжилтэн М.Баярмаа, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Кадастрын хэлтсийн дарга П.Баянтүмэн, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Кадастрын хэлтсийн дарга Б.Батжавхлан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх М.Отгон нар байлцав.

**Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийн хэлэлцүүлэг асуулт, хариултаар үргэлжлэв.**

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ж.Энхбаяр, Б.Тулга нарын тавьсан асуултад Гадаад харилцааны дэд сайд Г.Амартүвшин, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Д.Бат-Өлзий, Хууль зүй, дотоод хэргийн яамны Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтсийн дарга А.Энх-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл нар хариулж, тайлбар хийв.

**Г.Тэмүүлэн:** Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

*Уг асуудлыг 17 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямба, мөн яамны Олон улсын гэрээ, хамтын ажиллагааны газрын дарга Ч.Нарантуяа, Цагдаагийн ерөнхий газрын дарга Ж.Болд, тус газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа нар байлцав.

Хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямба хариулж, тайлбар хийв.

**Г.Тэмүүлэн:** Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 17 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга С.Билэгтборзаяа, ахлах шинжээч Г.Энхболд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, мөн штабын Зэвсэгт хүчний агаарын цэргийн командлагч Б.Мөнх-Ирээдүй нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх С.Дунжидмаа нар байлцав.

Хуулийн төслийн талаарх тусгайлсан ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар танилцуулав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Б.Тулга, Д.Ганбат нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба нар хариулж, тайлбар хийв.

*Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Г.Тэмүүлэн:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, М.Бадамсүрэн, Б.Батбаатар, Н.Батсүмбэрэл, П.Наранбаяр, Х.Тэмүүжин, Л.Энхнасан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “түүнтэй” гэснийг “Зэвсэгт хүчний тухай хууль, Иргэний нисэхийн тухай хуультай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 9  
Бүгд: 17  
47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Тулгын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Тулгын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17

### 58.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, М.Бадамсүрэн, Б.Батбаатар, Н.Батсүмбэрэл, П.Наранбаяр, Х.Тэмүүжин, Л.Энхнасан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “түүнтэй” гэснийг “Зэвсэгт хүчний тухай хууль, Иргэний нисэхийн тухай хуультай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтын “олон улсын сургууль, хамтарсан болон бие даасан” гэснийг “нисэхийн багийн” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.2, 4.1.7, 4.1.11, 4.1.14, 4.1.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.2.“аюулд нэрвэгдсэн агаарын хөлөг” гэж агаарын хөлөг нислэг үйлдэх, хөөрөх, буух, явгалах үед агаарын хөлөг гэмтэж, агаарын хөлөг болон зорчигчдод аюул учирч, аргагүйдсэн нөхцөлд буулт хийсэн эсхүл бүрэн эвдэрсэн хөлгийг;

4.1.7.“олон улсын нислэг” гэж улсын агаарын хөлгөөр Монгол Улс, гадаад улс хооронд үйлдэх нислэгийг;

4.1.11.“улсын агаарын хөлөг” гэж төрийн цэргийн, хууль сахиулах болон төрийн тусгай чиг үүргийн хэрэгжүүлэгч байгууллагын нисэх онгоц, нисдэг тэрэг, бусад агаарын хөлгийг;

4.1.14.“цэргийн зориулалттай нисэгчгүй нисэх хэрэгсэл” гэж цэргийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах нисэгчгүй болон зайнаас удирдах агаарын хөлгийг;

4.1.16.“улсын нисэхийн багц дүрэм” гэж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичгийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

### **“5 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх**

5.1.Монгол Улсын Их Хурал улсын нисэхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн “улсын нисэхийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг батлах;” гэсэн 6.1.4 дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 6.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.3.улсын нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, татан буулгах, хамтран ашиглах асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын санал болгосноор Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн шийдвэрлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “нисэхийн” гэсний дараа “хяналтын” гэж нэмж, мөн зүйлийн 7.1.2 дахь заалтын “шинжээч /байцаагч/-ийг томилох” гэснийг “шинжээчийг томилох, чөлөөлөх” гэж, мөн зүйлийн 7.1.5 дахь заалтын “цагийн хөлсний үнэлгээний тусгай норм, зэрэг, зэрэглэлийг” гэснийг “цагийн үнэлгээ, зэрэг, зэрэглэлийн нэмэгдлийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.3, 7.1.4 дэх заалт нэмэх:

“7.1.3.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комиссын дүрмийг батлах;

7.1.4.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинэчлэн шалгах комиссыг томилох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтын “мэргэжлийн үнэмлэх,” гэсний дараа “нислэгт тэнцэх чадварын” гэж нэмж, мөн зүйлийн 8.2.3 дахь заалтын “хөтлөх” гэснийг “бүрдүүлэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 8.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.2.5.улсын нисэхийн аэродромыг бүртгэх, гэрчилгээжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалтын “хуулийн” гэсний дараа “8.2 дугаар зүйлийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.4 дэх хэсэг нэмэх:

“10.4.улсын агаарын хөлгийн засвар, техникийн үйлчилгээ болон нисэх баг, инженер, техникийн бүрэлдэхүүний сургалтын тодорхой хэсгийг эдийн засгийн үр ашиг, чанар, аюулгүй байдлыг харгалзан дотоодын болон гадаадын гэрчилгээжсэн хувийн хэвшлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Энэ тохиолдолд тавигдах шаардлага, журмыг улсын нисэхийн багц дүрмээр тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.1.1, 10.1.2 дахь заалт болгох:

“10.1.1.нислэгийн үйл ажиллагааг хариуцсан нэгжтэй байх;

10.1.2 нь шалгагч зэрэглэлтэй нисгэгч, инженерийг томилох, чөлөөлөх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.1.3 дахь заалт болгох:

“10.1.3.Улсын нисэхийн багц дүрэм болон агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан дүрэм, зааврын дагуу нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын “улсын агаарын хөлөг,” гэсний өмнө “энэ хуулийн 4.1.3-т зааснаас бусад” гэж нэмж,

мөн зүйлийн 10.1.4 дэх заалтын “тасралтгүй” гэснийг, мөн зүйлийн 10.1.5 дахь заалтын “заавал” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.6 дахь заалт нэмэх:

“10.1.6.энэ хуулийн 14.1.2, 14.1.3, 14.1.4-т заасан нислэг үйлдэхэд зорчигчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн даатгалыг гэрээ байгуулагч тал хариуцах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалтын “бүртгэлийн гэрчилгээ нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах,” гэснийг “хасах, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, хүчингүй болгох;” гэж, мөн зүйлийн 11.1.11 дэх заалтын “хэрэгслийг бүртгэх,” гэснийг “хэрэгсэл, түүний удирдлагын системийг бүртгэх,” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “заасны дагуу” гэсний дараа “улсын агаарын хөлгийн бүртгэл” гэж, мөн хэсгийн “бүртгүүлээгүй,” гэсний дараа “нислэгт тэнцэх чадварын гэрчилгээгүй улсын” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12.3 дахь хэсэг болгох:

“12.3Улсын агаарын хөлөг нь нислэгийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангасан нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн “Улсын агаарын хөлгийг бүртгэх, бүртгэлээс хасах, нислэгт тэнцэх чадварыг тодорхойлох, гэрчилгээ олгох, сунгах, цуцлах үйл ажиллагааг Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулна.” гэсэн 12.6 дахь хэсэг, мөн зүйлийн “Энэ хууль болон Улсын нисэхийн багц дүрмийг зөрчсөн тохиолдолд агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно.” гэсэн 12.7 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 5  
Бүгд: 17

70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.6 дахь хэсэг нэмэх:

“12.6.Энэ хуулийн 10.1.5-д заасан даатгалыг улсын төсвийн санхүүжилтээр шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.3.Агаарын хөлгийн дарга нислэгийн аюулгүй байдалд аюул тулгарсан тохиолдолд улсын агаарын хөлөгт байгаа зорчигчдын амь насыг аврах зорилгоор нислэгийн төлөвлөгөө болон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн өгснөөс өөр шийдвэр гаргах эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийн “үүрэг гүйцэтгэгч” гэснийг “ажиллуулж” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.7.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрээгээр ажиллах гадаад улсын иргэн, хуулийн этгээдэд улсын агаарын хөдөлгөөний нисэх, техник үйлчилгээ хийх эрхийг дараах шаардлагыг үндэслэн олгоно:

13.7.1.мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ нь хүлээн зөвшөөрөгдсөн байх;

13.7.2.үндэсний аюулгүй байдал, эрсдэлийн үнэлгээ болон шалгалт хийгдсэн байх;

13.7.3.улсын агаарын хөлөг эзэмшигч байгууллагатай төрийн нууцын хууль тогтоомжийн дагуу нууцын баталгаа, нууц хадгалах гэрээ байгуулсан байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.6 дахь хэсэг нэмэх:

“14.6.Энэ хуулийн 14.1.2-т заасан нислэгийн аюулгүйн хамгаалалтыг хангах асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хамтарсан журмаар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 5

Бүгд: 17

70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “аэродром ашиглах үйл ажиллагаа, түүнд тавигдах шаардлагыг” гэснийг “ашиглах, түүний бэлэн байдлыг” гэж өөрчилж, мөн зүйлийн “Цэргийн зориулалтын нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, татан буулгах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын санал болгосноор Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн Засгийн газар шийдвэрлэнэ гэсэн.” 16.2 дахь хэсэг, мөн зүйлийн “Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын нисэхийн аэродром байгуулах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох тухай саналыг боловсруулж Засгийн газраар шийдвэрлүүлнэ.” гэсэн 16.3 дахь хэсэг, мөн зүйлийн “Улсын нисэхийн аэродромын бүртгэлийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 5

Бүгд: 17

70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн “Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналтыг энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллага хэрэгжүүлнэ.” гэсэн 18.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 18.3 дахь хэсгийг 18.2 дахь хэсэг болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.3.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.2.1, 18.2.2 дахь заалт болгох:

“18.2.1 эрх бүхий албан тушаалтнаас олгосон албаны үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэх;

18.2.2.албан үүрэг гүйцэтгэхтэй холбоотой албан шаардлага, зөвлөмж, дүгнэлт гаргах, хэвлэмэл хуудас хэрэглэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн “дээрх заалтын дагуу хийгдэх үйлдэл, байцаагчийн үүрэг даалгаврыг гүйцэтгэх хугацаа болон бусад нэмэлт зохицуулалтыг Улсын нисэхийн багц дүрмээр нарийвчлан зохицуулна.” гэсэн 18.3.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.4.4 дэх хэсэг нэмэх:

“18.4.Цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгслийг энэ хуулийн 11.1.11-д заасан шаардлага хангаагүй тохиолдолд ашиглахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.1.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах чиглэлээр зорчигчийн бие, ачаа тээшинд агаарын хөлгийг эзэмшигч болон мэргэжлийн байгууллага холбогдох дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг хийнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.4 дэх хэсэг нэмэх:

“19.4.Улсын нисэхийн үйл ажиллагаанд ашиглагдах мэдээллийн технологи, навигаци, хяналт, нислэгийн удирдлагын систем нь кибер аюулгүй байдлын шаардлагад нийцсэн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “Эрэн хайх” гэсний өмнө “Улсын агаарын хөлгийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “эрлийн ажлыг зогсоох шийдвэрийг уг агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын саналыг үндэслэн” гэснийг “мэргэжлийн комиссын саналыг үндэслэн эрлийн ажлыг зогсоох шийдвэрийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.2, 22.4, 22.5, 22.6, 22.7 дахь хэсгийг нэмэх:

“22.2.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь осол, зөрчлийг дахин давтагдахаас урьдчилан сэргийлнэ.

22.4.Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналт, осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцох албан тушаалтан нь агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын агаарын хөлгийг худалдан авахтай холбоотой ажиллагаанд шууд болон шууд бус ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол худалдан авах ажиллагаанд оролцохоос татгалзана.

22.5.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцох ерөнхий шинжээч, комиссын гишүүд нь улсын агаарын хөлгийг үйлдвэрлэгч болон засвар, техникийн ажиллагааг хариуцах байгууллагатай ашиг сонирхлын зөрчилгүй эсэх талаарх эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.

22.6.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны талаарх баримт мэдээллийг устгах, өөрчлөх, нуун дарагдуулах, задруулахыг хориглоно.

22.7.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны нууцад хамаарахаас бусад мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн гарчгийн “бүрэн эрх, чиг үүрэг” гэснийг “эрх, үүрэг” гэж, мөн зүйлийн 23.1 дэх хэсгийн “бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэснийг “эрхтэй” гэж, мөн хэсгийн 23.1.2 дахь заалтын “хүн” гэснийг “албан тушаалтан” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 23.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.1.1.албан үүргээ гүйцэтгэхдээ улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага болон шаардлагатай бусад газар саадгүй нэвтрэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.2.3 дахь заалтын “дүрмийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах” гэснийг “дүрмийн төслийг боловсруулах” гэж өөрчилж, мөн зүйлийн “улсын агаарын хөлгийн нислэг-техникийн осол, зөрчлийн шалтгааныг үнэн зөв тогтоох, шаардлагатай мэдээ, судалгаа, бусад баримт бичгийг холбогдох этгээдээс шаардан гаргуулж авах.” гэсэн 23.1.6 дахь хэсэг, мөн зүйлийн “улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс томилуулах тухай саналаа батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн гарчгийн “комисс, түүний бүрэн эрх” гэснийг “комиссын чиг үүрэг” гэж, мөн зүйлийн 24.1 дэх хэсгийн “түүний бүрэн эрх” гэснийг “дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:” гэж, мөн зүйлийн 24.1.1 дэх заалтын “зүйлст хяналт хяналтаа тогтоох” гэснийг “зүйлсийг хяналтад авах” гэж, мөн зүйлийн 24.1.5 дахь заалтын “болсон” гэснийг “улсын” гэж, мөн зүйлийн 24.3 дахь хэсгийн “уг осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ” гэснийг “осол, зөрчил гаргахгүй байх талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлнэ.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**Найруулгын санал:**

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “зохицуулалт,” гэсний дараа, 8 дугаар зүйлийн 8.2.6 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.2, 13.4 дэх хэсгийн “агаарын” гэсний өмнө, 21 дүгээр зүйлийн гарчгийн “нэрвэгдсэн” гэсний дараа “улсын” гэж тус тус нэмж, төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын “цогцолбор” гэснийг “цогц” гэж өөрчилж, төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “гарсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

*Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “... 9.1.1, 9.1.2-т...” гэснийг “9.1.2, 9.1.6-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**Найруулгын санал:**

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсгийн гаргасан, Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх гэсэн саналыг дэмжье санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн үг хэлэв.

*Уг асуудлыг 18 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 32 минут үргэлжилж, ирвэл зохих 29 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 58.6 хувийн ирцтэйгээр 18 цаг 17 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
16 цаг 45 минут.

### **АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Та бүхэнд ирцийг танилцуулъя. Жуковын Алдаржавхлан гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Сүрэнжавын Лүндэг гишүүн, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Буяагийн Тулга гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирснээр Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна.

2026 оны 06-р сарын 03-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Алх нь ирээгүй байна. Хэлэлцэх асуудал руугаа орцгооё. 3 асуудал байна. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улс /ОХУ/-ын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар /ЗГ/, ОХУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төсөл зөвшилцөх асуудал өмнө нь хэлэлцэж байсан, үргэлжилж хэлэлцэхээр байгаад байгаа. 2 дугаар асуудал, Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс /БНЧУ/ хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл байна. 3 дугаар асуудал, Улсын нисэхийн тухай хууль шинэчилсэн найруулга дээр Байнгын хорооноос байгуулагдсан ажлын хэсэг ажиллаад анхны хэлэлцүүлэгт бэлдсэн байгаад байгаа. Ийм 3 асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

***Нэг.Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2026.04.20-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, үргэлжилнэ/***

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын ЗГ, ОХУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулж ирээрэй.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн өмнө нь танилцуулж байсан. Гадаад харилцаа яам /ГХЯ/-наас дэд сайд Амартүвшин, тус яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Бат-Өлзий, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар /ТӨБЗГ/-аас

Цэнгэл дарга, Нарангэрэл тус газрын Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтсийн дарга, Баярмаа Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн, бусад газраас Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Зөвшөөрөл бүртгэлийн хэлтсийн дарга Энх-Эрдэнэ, Нийслэлийн Засаг дарга /НЗД/-ын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч дарга Амартүвшин, Нийслэлийн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Кадастрын хэлтсийн дарга Баянтүмэн, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Кадастрын хэлтсийн дарга Батжавхлан гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байгаа юм байна.

Өмнөх бид энэ хэлэлцээрийн төслийг хэлэлцэж байсан өнөөдөр үргэлжлүүлж хэлэлцэж байгаа. Гишүүдээс, Байнгын хорооны гишүүдээс хүсэлт тавьсны дагуу ГХЯ болоод ТӨБЗГ-аас нэмэлт мэдээллүүдийг нэхэж гаргаж авсан байгаа. Ингээд нэмэлт мэдээллийг ЗГ-аас ирүүлснийг гишүүдэд бид өмнөх долоо хоногт хүргүүлсэн. Нэмэлт мэдээлэлтэй холбоотойгоор асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу? Энхбаяр гишүүнээр тасалъя. Анар гишүүн микрофоныг нь өгье.

**Ч.Анар:** Оройн мэнд Байнгын хорооны гишүүд. Ажлын хэсгээс нөгөө хаалттай хуралдаан дээр асууж байсан асуултыг дахин тодруулж асууя. Нөгөө өмч, хөрөнгө шилжүүлэхтэй холбогдолтой энэ газрын эдэлбэр газрыг цаашид ашиглах нөхцөлийг 99 жил гэдэг хугацааг нөгөө анх ашигласнаас нь хойш Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлээс нь тооцохгүй юу, яагаад шилжүүлсэн өдрөөс хойш 99 жил гэж байгаа вэ? Тэгэхээр өнөөдрөөс хойш үндсэндээ бараг 100 жил энэ объект маань татан буугдсан ч гэсэн тэр ашиглах эрх нь нээлттэй байна гэсэн үг үү? Энэ асуултыг, бусад асуултаа ер нь асуучихсан даа.

**Г.Тэмүүлэн:** Анар гишүүний асуултад хариулъя. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Цэнгэл дарга индрийн микрофоныг өгье. Индэр дээрээс. Цэнгэл дарга асуултад хариулъя.

**Б.Цэнгэл:** Анар гишүүний асуултад хариулъя. Хэлэлцээр байгуулагдсан өдрөөс хойш энийг тооцож явъя гэдэг байдлаар явж байгаа. Бид яагаад 99 жил гэдэг хугацааг энд авч ашиглаж байгаа юм бэ гэхээр 19 онд энэ 2 улсын олон улсын хэлэлцээр 19 онд байгуулагдсан. Энэ дээр үл хөдлөх хөрөнгийн 1 дүгээр шатыг хэлэлцээрийг соёрхон баталсан байгаа 2 улсын парламент. Энэ дээр 60 дээр нэмэх нь 40 гэдэг байдлаар 19 оны хэлэлцээр батлагдсан юм, УИХ соёрхон баталсан. Өөрөөр хэлбэл эхний удаадаа 60 жилээр өгөөд, сунгахдаа 40 жилээр байх юм гээд. Үндсэндээ энэ 60 дээр нэмэр нь 40 гэхээрээ 100 жил болчихоод байгаа юм.

Тэр үед Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд энэ тоо байсан шүү дээ. Тэгээд дараа нь Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиас энэ тоог авч хаясан. Тийм учраас бид энэ 60 дээр нэмэр нь 40 буюу 100 жилийн асуудал ярихад хүнд боллоо. Тийм учраас энийг эргэж ярина гэж 2 улсын хамтарсан ажлын хэсгийн хурал дээр олон талаас нь ярьсан. Тэгээд бид манай ажлын хэсэгт Хууль зүйн яамны төлөөлөл байдаг. Тэгэхээр албан ёсоор Хууль зүйн яам энэ дээр гаргалгаа гаргаж, албан ёсоор бичгээр саналаа өг гэсэн. Ингээд Хууль зүйн сайдын гарын үсэгтэй хариу ирэхдээ Иргэний хуулиа баримтлаад энэ дээр 99 жил гэдэг тоог энэ хэлэлцээр дээр авч явах нь зүйтэй гэдэг ийм Хууль зүйн яамны байр суурь илэрхийлсэн. Тэгээд энэ байр суурийг Хууль зүйн яамны газрын дарга Энх-Эрдэнэ та тайлбарлачих нь зөв байх гэж бодож байна.

**Г.Тэмүүлэн:** Ерөнхийдөө ойлгомжтой болчихсон байх. Анар гишүүн болох уу? Индэр дээр Хууль зүйн яам албан тушаалаа танилцуулаарай.

**А.Энх-Эрдэнэ:** Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтсийн дарга Энх-Эрдэнэ. Ерөнхийдөө бол Газрын тухай хуулиар тусгай хэрэгцээний газар, тусгай хэрэгцээний газар байгаа. Газрын тухай хуульд юу гэж заасан бэ гэхээр гадаадын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллага, тэгээд гадаадын хуулийн этгээд нь тусгай хэрэгцээний газар ашиглаж болно, ашиглахдаа бол УИХ дээр соёрхон баталсан гэрээний журмаар батална гээд Газрын ерөнхий хууль байгаа.

Урьдын хэлэлцээр бол энд ОХУ, Монголын хэлэлцээр дээр бол урьдын 1 дүгээр транш (tranche) дээр 60, 40 гэдэг сая Цэнгэл даргын хэлснээр яг энэ 100 жилээ барьж явъя гэдэг санал ажлын хэсэг дээр тохироод, манайх бол Газрын тухай хуулиараа сунгаад явах юм байна, газар ашиглах нь бол Иргэний хуулиа барьж 150 дугаар зүйлийн нэгийг нь бариад явах нь зүйтэй юм байна гэсэн албан ёсны санал өгөөд энэ санал дээр л.../минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Анар гишүүн нэмж тодруулъя.

**Ч.Анар:** Сая асуултаа л энэ 99 гэдэг тоо хаанаас гарч ирээд байгаа юм бэ? Энэ чинь өмч, хөрөнгө шилжүүлэхээс гадна газрыг 99 жилээр ашиглуулах хэлэлцээр л болчихоод байгаа юм. Яагаад анх объект ашиглалтад орсноос нь хойш 99 жилээр тооцож хэлэлцээрт орох боломж байгаагүй юу? 99 жил гэдэг тоо хэлэлцээр соёрхон баталснаас хойш 99 жил газар ашиглуулах гээд байгаа.

**Г.Тэмүүлэн:** Индрийн микрофоныг өгье.

**А.Энх-Эрдэнэ:** ХЗДХЯ-ны хэлтсийн дарга Энх-Эрдэнэ хариулж байна. Иргэний хуулийн 150 дугаар зүйл нь өөрөө бусдын газар дээр барилга байгууламж барих эрх гэж байгаа юм. Бусдын газар дээр барилга байгууламж барих эрх гээд, 150.3-т нь болохоор барилга байгууламж барих эрх нь тодорхой заавал хугацаатай байх бөгөөд 99 жилээс хэтрэхгүй байна гэсэн байгаа. Энэ хугацааг л барьсан юм. Энэ бол бид хэлцээрээ төсөл дээрээ л явж байгаа юм. Ер нь бол дээд тал нь 99 байна, тэрнээс хэтрэхгүй байна гэсэн. Энийг багасгах эсэх нь бол Их Хурлын гишүүд, Их Хуралд оруулж ирж байгаа төслөөр л тэгж байгаа юм. Энийг өөрчилж болно. Гэрээ байгуулсан өдрөөс хойш. Яагаад гэвэл энэ объектууд нь маань өөрсдөө барилгынх нь эдэлгээний хугацаа нь өөр, өөр байхгүй юу, 60 жил болчихсон, 10 жил болчихсон, 20 жилтэй гээд гэх мэтчилэн өөр байгаа учраас иргэний хуулиа бариад тэгээд ХЗДХ-ийн сайдаас.../минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Анар гишүүн нэмж тодруулах уу? Анар гишүүн нэмж тодруулъя.

**Ч.Анар:** Энэ 150.3 Газрын тухай хуулийн заалтыг нь ойлгоод байгаа юм. Зүгээр энэ анх энэ өмч, хөрөнгө чинь зарим нь 1934 он, зарим нь 1970 гээд янз янзаар байгаа шүү дээ. Тэгэхээр тэр үеэс нь хойш 99 жилээр хэлэлцээртээ оруулж тооцож болохгүй юм уу? Энэ хуулиа ашиглаад гэж л асуугаад байгаа юм. Одоо энэ дээр орж ирснээр хэлэлцээр соёрхон баталснаас хойш 99 жил байгаа байхгүй юу. Тэгэхээр Газрын тухай хуулиа баримтлах юм бол анх өмчлөлд ОХУ буюу хуучин ЗХУ-ын өмчлөлд бүртгэгдсэн өдрөөс нь хойш 99 жил байж болохгүй юм уу? Хуулиа яг хэрвээ тэгж тайлбарлаж болох юм шиг л харагдаад байна л даа.

**Г.Тэмүүлэн:** Анар гишүүний асуултад хариулъя нэмэлт асуултад, хэн хариулах вэ? Цэнгэл дарга ТӨБЗГ. Индрийн микрофон.

**Б.Цэнгэл:** Анар гишүүний асуултад хариулъя. Бид 1 дүгээр транш буюу 1 дүгээр шатны хэлэлцээрийг 19 онд 2 улсын парламент соёрхон баталсан. Одоо оруулах гэж байгаа энэ 99-ийн нэгж объект өөрөөр хэлбэл одоо бүртгэлгүй яваад байгаа асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр бид өнөөдөр энэ хэлэлцээрээр ямар асуудлууд шийдэх гээд байгаа юм бэ гэхээр 1 дүгээрт, Зөвлөлт социалист холбоот улс гэдэг хуучин улсынх нь нэрийг нь ОХУ болгож нэг өөрчлөх асуудал яригдаж байгаа юм. 2 дугаарт, энэ бүртгэлгүй байгаа юмыг бүртгэлжүүлээд гэрчилгээжүүлэх асуудал яригдах юм. Тэгэхээр энэ хэлэлцээр соёрхон батлагдаж байж, эрх зүйн тэр харилцаа нь үүсэж байгаа учраас хэлэлцээр байгуулагдсанаас хойш 99 жил гэдэг ийм агуулгаар энд орсон юм. Зүгээр яах вэ манай Хууль зүйн яамныхан хэлж байна. Иргэний хуулиа баримтлаад ийм байдлаар нь 99 жил гэж оруулъя гэж байгаа.

Гэхдээ өмнө нь зүгээр 60 жил, тэгээд сунгах асуудлаа ярья гэдэг байдлаар 19 оны хэлэлцээрийг соёрхон баталсан. Сунгалт нь өөрөө 40 болчихоор 100 болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр бид Хөрөнгө оруулалтын хуульд энэ өөрөө хасагдсан учраас одоо энэ асуудлыг ярих боломжгүй гэж үзээд Хууль зүйн яам 99 жилээс хэтрэхгүй гэдэг агуулгаар нь л ер нь явъя гэдэг л ийм зарчим барьсан. Гишүүд зарчмын санал гаргах юм зүгээр 60 гэдэг, тухайлбал энэ нэг бид сая судалгаа авч үзсэн Их Хурлын гишүүдээс гаргасан хүсэлтийн дагуу. Ер нь 15-аас 80 хүртэл жилээр хамгийн дээд тал нь 80 хүртэл жилээр НЗД ингээд олгосон ийм хугацаа байна. Тийм тэгэхээр энэ зүгээр яг 90, 100 гэдэг тоог ер нь л авч хэрэглэсэн тохиолдол байхгүй юм байна лээ. Тийм. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Энхбаяр гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Ж.Энхбаяр:** Гадаад яамнаас асуулт байна. Энэ өөрөө олон улсын гэрээ конвенцоор зохицуулж байгаа байх гэж бодож байгаа. Монгол Улс гадаадад хэчнээн хөрөнгө эзэмшиж байна, хэчнээн газар ашиглаж байгаа тэгээд энэ маань ийм харилцан олон улсын ийм жишиг байгаа гэдгээ тайлбарлахгүй сөрөг ойлголт. Бид газраа ингээд гаднынханд 99 жилээр өгөх гэж байгаа агуулга яваад байна, болмооргүй байгаа юм. Тэгэхээр харилцан ийм байдаг. Монгол Улс гадаадад тэдэн байшин барилга, газар эзэмшиж байгаа ийм гэрээ хэлэлцээртэй байгаа. Ер нь тэгээд л ганц харилцан ашигтай харилцан, харилцаа тэнцвэртэй байх л зарчим шүү дээ. Тийм биз? Бид энд 99 жил өгч байгаа. Нөгөө талдаа энэ хэмжээнийхээ гэрээ хэлэлцээрийг л шаардана шүү дээ. Тэрийгээ Гадаад яам барьж чадаж байгаа юу. Нэг ийм асуулт.

**Г.Тэмүүлэн:** Энхбаяр гишүүний асуултад хариулъя ГХЯ-наас дэд сайд Амартүвшин баярлалаа.

**Г.Амартүвшин:** Гадаад хэргийн дэд сайд Амартүвшин байна. Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Энэ бүртгэгдэх гэж байгаа үл хөдлөх хөрөнгүүд тусгай хэрэгцээний буюу дипломат статусгүй үл хөдлөх хөрөнгүүд. Тийм болохоор манай бусад улсад харилцан адил байх зарчмаар 2 улсын олон улсын гэрээ хэлэлцээрээр эзэмшиж байгаа газар объектоос жоохон ялгаатай. Манай гадаад улсад эзэмшиж байгаа ЭСЯ, элчин сайдын өргөө дипломат статустай байшин, барилга байгууламж, объектууд 2 улсын ЗГ хоорондын хэлэлцээрийн дагуу явж байгаа. Бусад ЗГ болон хувь хүн, иргэний гадаад улсад эзэмшиж байгаа өмч нь тухайн улсынхаа дотоодын

хууль тогтоомжоор зохицуулагдаж байгаа. Үүгээрээ ялгаатай байгаа. Тэр нарийн манай гадаадад эзэмшиж байгаа тоон мэдээллийн талаар ТӨХ-ноос энд бэлтгэсэн тодорхой тоон статистик баримтуудаа хэлнэ.

**Г.Тэмүүлэн:** Нэмэлт хариулт өгье. ТӨХ-ноос ажил албан тушаалаа, нэрээ танилцуулаарай.

**Д.Нарангэрэл:** ТӨБЗГ-ын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Нарангэрэл. ОХУ-д манай гадаадад байгаа Монгол Улсын төрийн өмчийн тооллогын 22 оны тооллогын дүнгээс харахад ОХУ-ын Кызыл, Тува улсын ерөнхий консулын газар газартай 865 метр квадрат газар эзэмших эрхтэй, ОХУ-ын Эрхүү хотод байгаа Монгол Улсын ерөнхий консулын газар 1754 метр квадрат газартай, ОХУ-ын Улаан-Үдэ хотод байгаа ерөнхий консулын газар 3850 метр квадрат газартай, Москва хотод 4 байршилд тус газартай байгаа ЭСЯ-ны 1 дүгээр байр, 2 дугаар байр, зуслангийн газар гэсэн ийм байршлуудад 3 байршилд газар авсан. Өөрсдийнхөө нэр дээр эзэмших эрхийн гэрчилгээ авчихсан, биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрчихсөн ингээд бүртгэлтэй байж байгаа. Ер нь гадаадад манай Монгол Улсын төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн доорх 26 газар 62371 метр квадрат газар Монгол Улсын ЭСЯ-нуудын нэр дээр байгаа.

**Г.Тэмүүлэн:** Энхбаяр гишүүн нэмж тодруулъя.

**Ж.Энхбаяр:** Энэ үндсэндээ нөгөө Монголд хуучнаар Зөвлөлт социалист бүгд найрамдах улсын үед эзэмшиж байсан хөрөнгө, Монголд буцаан олгосон үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийн мэдээлэл байна уу? Их олон хот, хотхон, үйлдвэр, нисэх буудал, үйлдвэр, үйлчилгээний газар тэр талын мэдээлэл дурдчихвал их мэдээлэл тэнцвэртэй байх үүднээс хэрэгтэй байна. Тэрийг нь гаргаадахъя ийм юм Монгол Улсад бид үнэ төлбөргүй шилжүүлсэн, үнэ төлбөртэй нь ингээд шилжүүлсэн, одоо энэ чинь үлдээд байгаа үлдэгдэл нь. Энийгээ ингээд бүртгээд цаашдаа ОХУ бүрэн эрхийг нь хэрэгжүүлээд өмчлөлдөө аваад ингээд цаашаа өөрсдөө ашиглаад явъя гэж байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр бид энийгээ бүртгээд гэрчилгээг нь олгоод, Монголын дотоодын хууль дүрмийн дагуу газрыг нь хугацаанаас эзэмших, ашиглах эрхийг нь өгөөд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гаргаж өгөх ёстой юм болж байна. Зөв үү?

**Г.Тэмүүлэн:** ТӨХ-ноос хариулъя.

**Д.Нарангэрэл:** ТӨБЗГ-ын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Нарангэрэл. ОХУ-ын цэргийн хүч Монгол Улсад байрлах нь дуусгавар болсонтой холбогдуулж, 1993 онд ЗГ-ын хоорондын хэлэлцээр баталсан байдаг. Тэр хэлэлцээр дээр Монгол Улсад үнэ төлбөргүй цэргийн ангийн байршлуудад байсан хөрөнгүүдийг Монгол Улсын ЗГ-т үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн хөрөнгийг 1 дүгээр хавсралтаар нь оруулсан. Тэнд бол байршлыг нь тодорхой заасан 1993 оны хэлэлцээр байгаа. Худалдан борлуулах үл хөдлөх хөрөнгүүд гэсэн жагсаалтаар гарсан байдаг ОХУ-ын өөрсдөө худалдан борлуулах гэсэн ийм 2 төрлийн жагсаалт гарсан байдаг. Тэгээд цэргийн ангиудад тодорхой нэр бүхий хөрөнгүүдийг үнэ төлбөргүй шилжүүлж өгсөн байдаг. Ер нь бол 1 дүгээр траншны хэлэлцээр буюу 1 дүгээр үе шатны стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөрийн дагуу стратегийн юуны ОХУ-ын өмчийн дипломат статусгүй үл хөдлөх хөрөнгийн асуудлууд татваргүйгээр, төлбөргүйгээр, хугацаагүйгээр газар олгосон ийм хэлэлцээрүүд байсан 1971 оны хэлэлцээрт, 1979 оны хэлэлцээр.

Энэ 2 хэлэлцээрт хамаарах объектуудыг 2019 онд хэлэлцээрт өөрчлөлт оруулж төлбөртэй, хугацаатай болгож хувиргасан. Түүн дээр хугацааны хувьдаа 60 дээр нэмэх нь 40 гэсэн хугацаатай байсан. 19 оны хэлэлцээр дээр мөн ялгаагүй бид ажлын хэсэг ажиллаад, 2 хавсралттай гаргасан байдаг. Энэ хавсралт дээр Монгол Улсад үнэ төлбөргүйгээр шилжүүлэх ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар батлуулсан байгаа. Энэ ЗГ юу, УИХ-аар 2019 оны 09-р сард батлуулсан. Энэ орон сууцны 8 байрыг холбогдох инженерийн цахилгааны болон бусад хөрөнгөтэй нь шилжүүлэн авсан. Энийг БЗД, БГД, Дархан-Уул аймаг зэрэг ийм байршилд 8 байр дээр 550 гаруй өрх 1998 оноос хойш түрээслэн амьдарч байсныг нь Монгол Улсад энэ хэлэлцээрээр хүлээн авч улмаар ЗГ-ын шийдвэрээр ард иргэдэд нь үнэ төлбөргүй орон сууцны хувьчлалыг явуулаад, ард иргэдэд нь өгч хувьчилж өгсөн байгаа.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Тулга гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Б.Тулга:** Та бүгдийнхээ энэ өдрийн амар амгаланг эрье. ЗГ хоорондын хэлэлцээрийг дэмжиж байгаа. Хөрш орнууд олон жилийн түүхтэй. Тэгэхээр энэ өмч, хөрөнгийн асуудлаа цэгцлэх ёстой нь яах аргагүй хийх ёстой ийм ажлын нэг. Тэгэхээр энэ дээр энэ хэлэлцээр дээр байгаа хэлэлцээрийн төсөл дээр байгаа юун дээр хэд хэдэн санал хэлэх гэсэн юм. 1 дүгээрт, 9 дүгээр зүйл дээр та бүхэнд анзаарвал энэ талууд бичгээр харилцан зөвшөөрсний дагуу хэлэлцээр дуусгавар болж болно гэсэн заалт байна. Тэгээд энэ тохиолдолд талууд ийнхүү зөвшөөрч буй тухай дипломат нот бичиг солилцсоноос 180 хоногийн дараа энэхүү хэлэлцээрийн үйлчлэл дуусгавар болно. Залгаад дуусгавар болсон ч гэсэн дараагийн хэлэлцээр байгуултал өмч, хөрөнгө нь ямар нэгэн хугацаагүйгээр газрын ашиглах эрх, тэгээд объектууд нь нөгөө талдаа байна гэсэн ийм заалт орсон байна. Тэгэхээр энэ дээр зарчмын ийм санал гаргаж байна, санал гаргаж болно биз дээ? Энэ дээр ямар санал гаргаж байна гэхээр энд гэрээг шинэчлэх тодорхой хугацаа зааж өгөхгүй бол гэрээгээ шинэчлэхгүй бол өмч нь тэр чигээрээ үлдчих ийм нэг зүйл харагдаж байна. Энийг та бүхэн албан ёсоор санал болгоод, хэлэлцээрийнхээ төсөлд оруулбал зөв байх гэж бодож байна. Тодорхой нэг жилийн хугацаатай гэдэг юм уу, 2 жилийн хугацаанд гэрээгээ шинэчлэх ёстой, хэрвээ шинэчлэхгүй бол өмчлөл нь буцаад Монгол талдаа ирэх ёстой гэдэг ийм заалтыг оруулж өгөх нь зөв байх.

2 дугаарт нь, 99 жилийг та бүхэн Анар гишүүний яриан дээр хөндчихлөө. Тэгээд Хууль зүйн яамнаас тайлбар хийхдээ Иргэний хууль баримталсан гээд байна. Гэхээр энэ дээр жоохон асуудал гарах байх. Яагаад гэвэл энэ чинь гадаад улсын өмчлөлийн объект, газар ашиглах тухай асуудал ярьж байгаа болохоос Монгол Улсын Иргэний хуулиар энэ жишиг авч явах нь буруу байх гэж бодож байна. Тийм учраас энэ Газрын тухай хуулиа баримтлаад юу гэдэг юм мэдээж хөрш орон, нөгөө талдаа аль, аль талдаа аятайхан байхын тулд тэр Газрын тухай хууль дээр байгаа 15-аас 60 жил хүртэл гэж байгаагаа баримтлаад, 60 жил гэдгээрээ ороод явчихвал яасан юм бэ? Тэгээд 60 жилийн дараа хэлэлцээрээ дахиад сунгаад л явна биз. Тэрийг заавал ч үгүй хэдүүлээ Иргэний хуульд оруулж ирээд, энэ 2 улсын хоорондын асуудал энэ дээр. Энэ чинь Монгол Улсын иргэнд нэг их шууд өмчлөх гэдэг юм уу эзэмших, ашиглах юм энэ дээр орж ирэхгүй шүү дээ. Тийм учраас энэ хугацаагаа 60 гэдэг болгочооч гэдэг ийм саналыг оруулъя. ТӨХ-н дарга өөрөө энэ дээр бол боломжтой гэж хэлж байх шиг байна.

3-д нь нэг асуулт байна. Энэ эзэмших асуудал маань гэрчилгээтэй болоод, өмчөө эд нар маань бүртгээд аваад, тэгээд захиран зарцуулах нь ОХУ-ын тал. Тэгэхээр одоо ЗГ-ын түвшинд байж байгаад ОХУ нь ЗГ нь хувийн хэвшилдээ энийгээ зарж борлуулаад, эсхүл шилжүүлээд ингээд явчихдаг. Гуравдагч этгээдэд шилжвэл энэ гэрээн дээр байгаа нөхцөлүүд шинэчилж байгуулах шаардлага үүсэх үү, энийг хэлэлцээрт тусгаж өгсөн байгаа юу гэдгийг нэг протоколд үлдээх ийм хүсэлтэй байна. Энэ дээр асуулт.../минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Тулга гишүүний асуултад хариулъя. ТӨБЗГ-ын дарга цэнгэл дарга.

**Б.Цэнгэл:** Тулга гишүүний асуултад хариулъя. Тулга гишүүн энэхүү хэлэлцээрийн үйлчлэл дуусгавар болсон тохиолдолд энэхүү хэлэлцээрийн 1 болон 2-р хавсралтад заасан ОХУ-ын эдэлбэр газар ашиглах эрх болон үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх, мөн түүнчлэн энэхүү хэлэлцээрийн 4-р зүйлд заасан барилга байгууламжийн өмчлөх эрх шинэ хэлэлцээр байгуулах хүртэл бүрэн хадгалагдана гэдэг асуудлыг хөндөж ярилаа. Тэгэхээр энэ дээр тодорхой хугацаа тавьж өгч болно гэж үзэж байна. Энийг бид манай Их Хурал ийм санал гаргасан учраас бидэнд, тухайлбал бид нөгөө хэлэлцээр байгуулах эрхээ авах гэж байгаа. Тэгэхээр энэ дээр энийг хөндөж тавьж болох байх гэж бид харж байна. Нөгөө нэг гэхдээ бид энийг яах гэж ингэж оруулсан бэ гэхээр хэлэлцээр дээр холбогдох эдэлбэр газрыг цаашид ашиглах нөхцөлийг талууд 99 жилийн хугацаа дуусахаас 2 жилийн өмнө хэлэлцээ хийх замаар тодорхойлно гээд оруулчихсан юм.

Өөрөөр хэлбэл хугацаа дуусахаас 2 жилийн өмнө дараагийнхаа асуудлыг сунгах эсэх тухай асуудлуудаа ярина шүү гэдэг ийм заалт оруулчихсан юм. Ингэж орчихсон учраас ард талд нь хугацаа тавиагүйгээр ингээд явчихсан нэг ийм юм байгаа юм. Гэхдээ таны саналыг Оросын талд тавих бүрэн бололцоотой гэж үзэж байна. Баярлалаа. Ер нь нөгөө бусдад ингээд дараа нь ингээд зарж үрэх, шилжүүлэх тийм юмыг ерөнхийдөө энэ хэлэлцээр хориглочихсон байж байгаа. Баярлалаа. Бат-Өлзий дарга танилцуулчих.

**Г.Тэмүүлэн:** Нэмж хариулъя, ГХЯ-наас Бат-Өлзий захирал.

**Б.Бат-Өлзий:** Сайн байцаана уу. ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Бат-Өлзий байна. Уг хэлэлцээрийн хавсралтад заагдсан байгаа нийтдээ яг 93 объект байгаа, 93 тоо гэдэг нь их тоо харагдаж байгаа боловч яг нарийн ингээд харвал тэдний 50 орчим хувь нь амины орон сууц байгаа. Энэ амины орон сууцыг Оросын тал өөрийнхөө ОХУ-ын нэр дээр яг хууль ёсны залгамжлагч гэдгээрээ шилжүүлсний дараа үүнийг зах зээлийнхээ эргэлтэд оруулах бүрэн боломжтой гэсэн үг. Ер нь бидний мэдээллээр энийг магадгүй жил болгон тэр 50 орчим орон сууцыг ингээд тоолоод байх хэцүү учраас зах зээлийн үнээр нь Монгол Улсын иргэдэд ч юм уу, гуравдагч этгээдэд заран борлуулах ер нь боломжтой болно гэсэн үг. Монгол Улсын иргэд тэнд амьдраад ОХУ-д түрээс төлөөд амьдардаг, тэрийгээ жил болгон түрээслэхгүйгээр ОХУ хэрвээ хүсвэл Монгол Улсын иргэдэд болон гуравдагч этгээдүүдэд зарлан борлуулах боломжтой гэсэн үг.

**Г.Тэмүүлэн:** Тулга гишүүн нэмж тодруулъя.

**Б.Тулга:** Тэгэхээр хэлэлцээрийн дагуу бол энэ гуравдагч этгээдэд шилжүүлж болохгүй, ялангуяа би газар, би минутаа сунгаж авна шүү энэ Цогтбаатар дарга юм

асуулгахгүй. Гуравдагч этгээдэд шилжинэ гэж болно гэж байгаа шүү дээ, энэ чинь мэдээж болох ёстой өмчлөлд бүртгэж байгаа учраас. Тийм учраас тэр түрүүний ярьдаг 99 жил гэдгийг заавал ч үгүй хуульд нийцүүлээрэй. Монгол Улсын Газрын тухай хуулиар 60 нэг. Тэгээд газар ашиглах эрхийг Орос улсын талд бүртгүүлээд юу гэдэг юм ашиглах эрхээ тэд компанитайгаа ч байдаг юм уу ингээд шилжүүлээд авлаа гэхэд гуравдагч гадаад улсын иргэн аввал яах юм бэ? Энийг зохицуулсан заалт байгаа юу нэг? Үгүй ээ яах вэ байгаа төслөөрөө болохоор болохгүй байгаад байна л даа Энхбаяр даргаа. Одоо байгаа төслөөрөө энэ чинь бид Монгол Улсын хуулиар Монгол Улсын иргэн 60 жилээр л хамгийн максимум газар авч байхад энүүгээр чинь болохоор 99 жилээр авчхаад буцаагаад өөр юу үүсчих гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг л ямар ч байсан 1 дүгээрт зохицуулж өгөөрэй гэж үзэж байгаа юм.

2-т нь энэ манай Дархан-Уул аймагт байгаа 7 дугаар байрны асуудал миний ойлгож байгаагаар энэ 19 оны хэлэлцээрээр шийдэгдсэн асуудал юм шиг байгаа юм тийм ээ Оросын талдаа бүртгэгдсэн. Монголын төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг дээр байгаа энэ 7 дугаар байрны асуудлыг ямар байдалтай шийдэж байгаа вэ гэдэг талаар мэдээлэл өгөөч? Манай энэ 7 дугаар байр бол насаараа энэ МТЗ-д ажилласан машинист, төмөр замын ажилчид байдаг ийм байр, тэгээд ганцаараа үлдчихсэн. Энэнээс болоод хөөрхийг өмчилж болдоггүй нас барчихвал хураалгачих гээд байдаг ийм аягүй хүнд байдалтай байдаг. Тийм учраас энэ байрны асуудлыг нэг ТӨХ тодорхой мэдээлэл өгөөч, яаж шийдвэрлэж байгаа вэ гэдэг тал дээр мэдээлэл өгөөч гэж хүсэж байна?

**Г.Тэмүүлэн:** Хэн хариулах вэ? ГХЯ Бат-Өлзий захирал, индрийн микрофон.

**Д.Бат-Өлзий:** Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Бат-Өлзий. Тулга гишүүний эхний асуултад хариулъя. Та түрүүн хэлсэн гуравдагч этгээдэд болон гадаадын иргэдэд зарах боломжтой уу гээд. Энэ нь өөрөө бид газраа ашиглуулах эрх өгч байгаа учраас зарах боломжгүй. ОХУ тухайн газрыг ашиглаж байгаа, эзэмшиж байгаа биш ашиглаж байгаа учраас түүнийг ямар нэгэн гадаадын иргэдэд болон гуравдагч этгээдэд зарлах зарах боломжгүй. Миний нөгөө нэг түрүүний хэлсэн зарах боломжтой объектуудын хувьд нь болохоор энэ амины орон сууцтай холбоотой асуудлууд байгаа. Тийм учраас манай Монгол Улсын газрыг аль нэг гуравдагч этгээдэд тэр дундаа гадаадын иргэдэд зарна, зарах, ашиглуулах ийм боломж, эрх нь үүсэж байна уу гэвэл үгүй гэдгийг хариулт өгье. 2 дахь асуулт нь.../минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Нэмж хариулъя. ТӨХ Цэнгэл дарга.

**Б.Цэнгэл:** Ер нь үл хөдлөх хөрөнгөнүүдийн хувьд зарим нь газартай, зарим нь газаргүй шүү дээ. Тийм түүгээрээ ялгагдана. Дархан-Уул аймгийн 7 дугаар байрны оршин суугчид удаа дараа асуудал тавьсан. Энийг бид ажлын хэсгийн шугамаар Оросын талд албан ёсоор ажлын хэсэг дээр хэлэлцэх асуудал дотор оруулчихсан байж байгаа. Ингээд Оросын тал тодорхой хугацаа аваад энэ асуудлыг Оросынхоо талд танилцуулсан байна лээ. Ингээд Оросын ЗГ-ын зүгээс ямар хариу өгсөн бэ гэхээр 2019 оны 1 дүгээр транш дээр энэ ОХУ-д бүртгэлтэйгээр гарсан. Энэнээс хойш иргэд нь санал тавиад байгаа тийм үү? Тэгэхээр шууд үнэ төлбөргүй өгөх асуудал энэ удаа яригдахгүй. Гэхдээ бид маш бололцооны үнээр худалдъя. Тэгэхээр та бүхэн энэ бололцооны үнээр худалдах бид санал тавья. Энийг нь та худалдаад аваач. Тухайлбал Улаанбаатар төмөр зам /УБТЗ/ энийг авч болно шүү дээ, яагаад гэхээр УБТЗ-ын л хүмүүс тэнд амьдарч байсан. Тийм учраас энэ

асуудал, гэхдээ үнийн санал ирүүлэхдээ маш боломжийн санал ирүүлсэн. Бид энийг нь УБТЗ-д албан ёсоор болон албан бусаар энэ асуудлыг Хэрлэн даргад уламжилсан. Тэгээд энэ нөгөө ганц Хэрлэн даргын өөрийнх нь шийдчих асуудал биш, нөгөө Совет дээр танилцуулагдаад, тэр дээр нь нэг жаахан дэмжлэг аваагүй юм уу гэж ойлгосон. Гэхдээ энэ асуудлыг бид орхиогүй байгаа цааш нь ахиж ярина. Тийм. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалт явуулахаар байгаа, санал хураалтад бэлтгэцгээе. ТӨБЗГ-ынхан, ГХЯ-ныхан сая гишүүдийн хэлсэн саналууд дээр анхаарч ажиллаарай. Тэгээд нэгэнт 1 талдаа болбол яах вэ мэдээж энэ олон улсын гэрээ, конвенцоор зохицуулагдаж байгаа харилцааны асуудал 2 улсын ЗГ хоорондын хэлэлцээрийн хүрээнд шийдэгдэж байгаа ийм асуудал байгаа. Тэгэхээр саяын тэр хугацаатай холбоотой, гэрээ шинэчлэх хугацаа гэдэг юм уу, зохицуулалттай холбоотой асуудлууд дээр тодорхой саналуудаа тавьж анхаарч ажиллаарай гэдэг саналыг хэлэх байна. Эргээд УИХ дээр чуулганаар орж хэлэлцэгдэж эцэслэн батлагдах, соёрхон батлах асуудал орж ирэхээр байгаа гэдгийг анхааралдаа авах ёстой. Санал хураалтыг явуулж эхэлье.

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эдэлбэр газар болон тэдгээрт байрлах үл хөдлөх хөрөнгийн объектуудын эрхийг Оросын Холбооны Улсын нэр дээр шинэчлэн бүртгэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Цогтбаатар гишүүний төхөөрөмж ажилласангүй. 17 гишүүнээс 10 гишүүн дэмжсэн байна. Дэмжсэнээр, Цогтбаатар гишүүн дэмжсэнээр орж байна. 17-оос 10 гишүүнээр дэмжигдлээ. Баярлалаа ажлын хэсгийнхэнд.

17.18 цаг

***Хоёр.Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/***

Дараагийн асуудалдаа орцгооё. Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон БНЧУ хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийг оруулаарай. Соёрхон батлах хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг ЗГ-ын гишүүн, ХЗДХ-ийн сайд Сайнбуянгийн Амарсайхан сайд танилцуулна. Амарсайхан сайдыг микрофонд урьж байна.

**С.Амарсайхан:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын гадаад харилцаа өргөжин хөгжихийн хэрээр иргэдийн гадаадад суралцах, ажиллах болон бизнес, аялал жуулчлалын, аяллын чиглэлээр харилцан зорчих явдал нэмэгдэж байгааг харгалзан Монголчууд ихээр зорчиж амьдарч, мөн ажил хөдөлмөр эрхэлдэг улс орнуудтай эрх зүйн туслалцаа, харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээ, хэлэлцээр байгуулах асуудалд тус яамнаас анхаарал хандуулан ажиллаж байна. Энэ хүрээнд Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон БНЧУ хоорондын хэлэлцээр нь 5 хэсэг, 29

зүйл, хавсралтаас бүрдэж байгаа бөгөөд хэлэлцээрийн хүрээнд зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэмт хэргийн зохион байгуулагчийг олж тогтоох чиглэлд талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх, олон нийтийн аюулгүй байдал, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд 2 улсын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцаж, түргэн шуурхай хамтран ажиллах боломжтой юм.

Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон БНЧУ хоорондын хэлэлцээрийн төслийг УИХ-ын ХЗБХ болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 03-р сарын 10-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэн дэмжиж, гарын үсэг зурах эрхийг ЗГ-т олгосноор уг хэлэлцээрт талууд 2025 оны 03-р сарын 10-ны өдөр БНЧУ-ын Прага хотноо гарын үсэг зурсан.

Энэхүү хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтад заасны дагуу эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон заавал соёрхон батлах олон улсын гэрээ бөгөөд мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу уг хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлж батлуулах юм. Хэлэлцээрийг соёрхон батлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**Г.Тэмүүлэн:** Амарсайхан сайдад баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. ХЗДХЯ-наас тус яамны Төрийн нарийн бичгийн дарга /ТНБД/-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбямба, тус яамны Олон улсын гэрээ, хамтын ажиллагааны газрын шинжээч Дөлгөөн, тус яамны Олон улсын гэрээ, хамтын ажиллагааны газрын дарга Нарантуяа, Цагдаагийн ерөнхий газар /ЦЕГ/-аас ЦЕГ-ын дарга, Дотоод хэргийн командлагч, цагдаагийн хурандаа Болд, тус газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Батзориг, тус газрын Гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Бат-Оргил гэсэн ийм бүрэлдэхүүнтэй оролцож байгаа юм байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулттай гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Ж.Энхбаяр гишүүнээр тасалъя. Энхбаяр гишүүн.

**Ж.Энхбаяр:** Одоо БНЧУ-д Монгол Улсын хэчнээн иргэн байнга оршин сууж, хөдөлмөр эрхэлж байгаа вэ? Өнгөрсөн хугацаанд үүссэн энэ эрүүгийн нөхцөл байдал, гэмт хэрэгт холбогдсон асуудлууд, судалгаа ямаршуухан байгаа юм бол. Тэр талын мэдээлэл асуугаадахъя?

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсгээс асуултад хариулъя. Индрийн микрофон, албан тушаалаа танилцуулаад асуултад хариулаарай.

**Б.Батбямба:** Энхбаяр гишүүний асуултад хариулъя. ХЗДХЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбямба байна. Өнөөдрийн байдлаар Чех улсад нийтдээ 15147 иргэн ажиллаж, амьдарч байгаа.

**Г.Тэмүүлэн:** Асуултад тодорхой хариулъя, нэмж хариулъя.

**Б.Батбямба:** 2025 оны байдлаар, одоогийн байдлаар 86 иргэн хэрэгт холбогдсон ийм мэдээлэлтэй байна.

**Г.Тэмүүлэн:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Алга байна, Санал хураалтад бэлтгэе. Санал хураалтыг явуулж эхэлъя. Цогтбаатар гишүүн, Цогтбаатар гишүүний төхөөрөмж болохгүй байна уу, давхар орчихсон юм болов уу? Би томъёоллыг нь уншиж танилцуулж байна.

Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд саналаа өгнө үү. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн оролцоноос 11 гишүүн дэмжсэн байна, 64.7 хувиар дэмжигдлээ. Санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүн байна уу? Тулга гишүүн? Тулга гишүүн танилцуулъя. Асуудлыг хэлэлцэж дууслаа. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

17.24 цаг

***Гурав.Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

3 дахь асуудалдаа орцгооё. Улсын нисэхийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой ажлын хэсгийнхнийг оруулъя. Ажлын хэсэг, танилцуулга мэдээлэл байгаа юу? Ажлын хэсгийн ахлагч, ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Анар гишүүн хийнэ. Анар гишүүний микрофоныг өгье.

**Ч.Анар:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2026 оны 04-р сарын 20-ны өдөр МУИХ-д өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын 2026 оны 05-р сарын 01-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2026 оны 05-р сарын 05-ны өдрийн 01-р тогтоомжоор Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Ч.Анар, УИХ-ын гишүүн Бадамсүрэн, Батбаатар, Батсүмбэрэл, Наранбаяр, Тэмүүжин, Энхнасан нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх бүрэлдэхүүнд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын холбогдох албан хаагчдыг төлөөллийг оролцуулан ажиллалаа.

Ажлын хэсэг нийт 3 удаа хуралдсан бөгөөд ажлын хэсэг холбогдох байгууллагуудаас нэмэлт мэдээлэл авах, төслийн зарим зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, саналын томъёоллыг бэлтгэх үүрэг чиглэлийг өгч, ажлын хэсгийн хуралдаанаар улсын нисэхийн аюулгүйн хамгаалалттай холбоотойгоор улсын

нисэхийн үйл ажиллагаанд ашиглагдах мэдээллийн технологи, навигаци, хяналт, нислэгийн удирдлагын системийг кибер аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэх талаар, байлдааны агаарын хөлгөөс бусад онцгой үүргийн, тусгай үүргийн болон захиалгат нислэгт үйлдэгдэхэд хамаарах агаарын хөлгийг даатгуулсан байх, улсын нислэгт техникийн осол, зөрчлийг шинэчлэн шалгах, техник засварын үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох албан тушаалтан нь ашиг сонирхлын зөрчилгүй байхаар, мөн цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгслийг удирдлагын системд бүртгүүлээгүй, гэрчилгээжүүлээгүй, хяналтын шаардлага хангаагүй тохиолдолд ашиглахыг хориглох талаар хуулийн төсөлд тус тус нэмж тусгасан бөгөөд хууль зүйн нэр, томъёог жигдлэн, хууль хоорондын нийцлийг хангах үүднээс зарим зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулж, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд танилцуулж байна.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар нийт 31 зарчмын зөрүүтэй санал, найруулгын 2 саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсгийн танилцуулгыг сонслоо. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. БХЯ-наас Батлан хамгаалахын сайд Батлут сайд, тус яамны дэд сайд Баасандамба, тус яамны ТНБД, хошууч генерал Ганхуяг, тус яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Гансүх, тус яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Улсын нисэхийн хэлтсийн шинжээч, хошууч Билэгтборзаяа, тус яамны ТЗУГ-ын ахлах шинжээч, хуулийн зөвлөх Энхболд. Ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг оролцож байгаа юм байна. Зэвсэгт хүчний Жанжин штабаас байна, Ганбямба дарга ирсэн байна. ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Сүнэрийн Ганбямба дарга ирсэн байна. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, бригадын генерал Бямбасүрэнгийн Мөнх-Ирээдүй гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байгаа юм байна.

Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ гэж заасны дагуу зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлнэ. Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү? Алга байна. Ажлын хэсэг саналтай байгаа юу? 1 дүгээр зүйл дээр байхгүй байна.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг 2 дугаар зүйл дээр саналтай юм байна. Төслийн талаарх саналын томъёоллыг уншиж танилцуулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Анар, Бадамсүрэн, Батбаатар, Батсүмбэрэл, Наранбаяр, Тэмүүжин, Энхнасан гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг ажилласан байна.

Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “түүнтэй” гэснийг “Зэвсэгт хүчний тухай хууль, Иргэний нисэхийн тухай хуультай” гэж өөрчлөх. Санал хураалтыг явуулъя. Санал хураалтад бэлтгэе. Энэ томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Санал хураах нь байна. Хэн дутуу орчхов? Тулга гишүүн, Ганбат гишүүн. Тулга гишүүн горимын санал гаргах уу?

**Б.Тулга:** Уучлаарай, би энэ төхөөрөмжтэйгөө будилаад юу яаж чадсангүй, бүртгүүлж чадсангүй, дахин санал хураалгаж өгнө үү.

**Г.Тэмүүлэн:** Дахин санал хураалтыг явуулъя. Тулга гишүүний гаргасан горимын саналаар, хүчингүй болгох санал хураалт явуулна санал хураалтад бэлтгэе. Санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай дараарай. 58.8 хувиар горимын санал дэмжигдлээ. Горимын санал дэмжигдсэн учраас өмнөх санал хураалт хүчингүй боллоо. Ингээд 2.1 дэх хэсэг дээр санал хураалтыг явуулъя дахин. Гишүүд анхааралтай байгаарай, дэмжье гэдгээр санал хураалтыг явуулна. Санал хураалт. 58.8 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. 3 дугаар зүйл дээр ажлын хэсгээс санал алга байна.

Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна, асуулт байна. Энхтүвшин гишүүн 4 дүгээр зүйлтэй холбоотойгоор асуулт асуух юм байна. Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Энэ одоогийн Хуулиар арилжааны зорилготой нислэг хийхийг байсныг өөрчлөөд захиалгат нислэг гэж оруулсан байгаа. Тэгээд энэ дээр болохоор энэ арилжааны шинжтэй нислэгүүд энд хамаарахгүй байхаар өөрөөр хэлбэл хувийн хэвшлийн салбартай улсын нисэх өрсөлдөхгүй байхаар иймэрхүү агуулга орж ирж байна гэж ойлгосон. Энэ ойлголт зөв үү? Тэгээд энийг хязгаарлаад зөвхөн хүний амь нас, эрүүл мэндийг аврах ийм чиглэлээр тусгай үүрэг гүйцэтгэх ийм чиглэлээр л захиалгат нислэгийг хийж болно гэж энэ хуулийн 4.1.5-аас болон 4.1.10-аас ингэж ойлгогдож байгаа энэ ойлголт зөв үү гэж.

**Г.Тэмүүлэн:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Батлут сайд, Батлут сайдын микрофоныг өгье, уншуулна та хуруугаа уншуулах байх. Батлут сайдын микрофон.

**Д.Батлут:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийн 4.1.5 дээр захиалгат нислэгийн тухай асуудлыг тодруулсан байгаа. Энүүгээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Улсын нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтад заасан Арилжааны нислэг гэснийг тус хуулийн төслөөр захиалгат нислэг гэж өөрчилсөн. Арилжаа гэдгийг Монгол хэлний тайлбар тольд бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, үнэт цаас, валют, эд зэрэг эд хөрөнгийг худалдах, худалдан авах замаар солилцох үйл ажиллагааг тайлбарласан бөгөөд улсын агаарын хөлгөөр иргэн, аж ахуйн нэгж нь яаралтай тохиолдолд захиалга өгөх журмаар нислэг үйлдэж байгаа тул захиалгат нислэг гэж өөрчилсөн гэж үзэж болно.

Тэгэхдээ энэ үндсэндээ гамшиг, ослын болон бусад үед яаралтай хүний амь нас, эрүүл мэндийг аврах болон тусгай үүрэг гүйцэтгэх чиглэлээр иргэн, хуулийн этгээдээсээ гаргасан хүсэлт, захиалгын дагуу үйлчилгээ үзүүлэх байгаа.

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулъя. Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтын “олон улсын сургууль, хамтарсан болон бие

даасан” гэснийг “нисэхийн багийн” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.2, 4.1.7, 4.1.11, 4.1.14, 4.1.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.2.“аюулд нэрвэгдсэн агаарын хөлөг” гэж агаарын хөлөг нислэг үйлдэх, хөөрөх, буух, явгалах үед агаарын хөлөг гэмтэж, агаарын хөлөг болон зорчигчдод аюул учирч, аргагүйдсэн нөхцөлд буулт хийсэн эсхүл бүрэн эвдэрсэн хөлгийг;

4.1.7.“олон улсын нислэг” гэж улсын агаарын хөлгөөр Монгол Улс, гадаад улс хооронд үйлдэх нислэгийг;

4.1.11.“улсын агаарын хөлөг” гэж төрийн цэргийн, хууль сахиулах болон төрийн тусгай чиг үүргийн хэрэгжүүлэгч байгууллагын нисэх онгоц, нисдэг тэрэг, бусад агаарын хөлгийг;

4.1.14.“цэргийн зориулалттай нисэгчгүй нисэх хэрэгсэл” гэж цэргийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах нисэгчгүй болон зайнаас удирдах агаарын хөлгийг;

4.1.16.“улсын нисэхийн багц дүрэм” гэж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичгийг;” Санал гаргасан ажлын хэсэг. Гишүүд анхааралтай, санал хураалтыг явуулъя. 58.8 хувиар дэмжигдлээ. 4 дүгээр зүйлээр санал хураалт явуулж дууслаа.

Шинэчилсэн найруулгын төслийн 5 дугаар зүйлтэй холбоотойгоор асуулттай гишүүд байна уу? Алга байна. 5 дугаар зүйл дээр ажлын хэсгээс санал байна.

Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

5.1.Монгол Улсын Их Хурал улсын нисэхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг явуулъя. Тулга гишүүн асуулттай байна. Тулга гишүүн.

**Б.Тулга:** Энэ сая 4.4-ийн юун дээр ч гарчихлаа. Одоо энэ 5 дээр гараад ирж байна л даа. Улсын нисэхийн үйл ажиллагаа гээд байх юм. Тэгэхээр чинь энэ чинь зөвхөн төрийн өмчит компани /ТӨК/ буюу төрийн юу явж байгаа төрийн үйл ажиллагаа явж байгаа энэ нисэхийн юмыг зохицуулаад, тэгээд улсын нисэх гэхээр нөгөө иргэнийх нь яах юм, хаягдчих юм уу, тусдаа байх юм уу? Тэгэхээр улсын нисэх гэдэг, Монгол Улсын нисэх гэдэг дотор иргэнийх гэж ойлгохгүй юм уу? Тэрэн дээр зүгээр тайлбар.

**Г.Тэмүүлэн:** Тулга гишүүний асуултад хариулъя Батлут сайд.

**Д.Батлут:** Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаар өөрөөр заагаагүй бол улсын, олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө гэж Улсын нисэхийн тухай 2.2 дээр заагдсан байна. Энэ Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны конвенцын иргэний болон улсын агаарын хөлөг гэсэн 3 дугаар зүйлийн А-д энэхүү конвенц нь гагцхүү иргэний агаарын хөлгийн хувьд хэрэглэгдэх бөгөөд улсын агаарын хөлгийн хувьд хэрэглэгдэхгүй гэж, мөн зүйлийн Б-д цэрэг, гааль,

цагдаагийн албанд ашиглаж байгаа агаарын хөлгийг улсын агаарын хөлөг гэж тооцно гэж зааснаар Улсын нисэхийн тухай хууль нь Чикагогийн олон улсын конвенцод заасан зохицуулалтаар үйлчлэхгүй юм.

Тэгэхээр энэ зохицуулалтаар үндсэндээ улсын нисэхийн үйл ажиллагаа дан ганц батлан хамгаалах салбартай хамааралтай бус ОБЕГ, ХХЕГ болоод цаашлаад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг яаралтай үзүүлэх, ЭМЯ хүртэл нисдэг тэрэгтэй болбол энэ улсын төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд үйлчилгээ үзүүлж байгаа нисдэг агаарын хөлгүүдтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг үүгээр зохицуулна. Үүнийгээ улсын нисэх гэж нэрлэхээр зохион байгуулагдаж байгаа гэж ойлгож болно.

**Г.Тэмүүлэн:** Санал хураалтыг явуулъя. Санал хураалтыг танилцуулчихсан байгаа 5 дугаар зүйл дээр. Дэмжье гэдгээр санал хураалтыг явуулъя. Баярлалаа, 58.8 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. 6 дугаар зүйл дээр ажлын хэсгээс саналтай байна. 4.Төслийн 6 дугаар зүйлийн “улсын нисэхийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг батлах;” гэсэн 6.1.4 дэх заалтыг хасаж, мөн зүйлийн 6.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.3.улсын нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, татан буулгах, хамтран ашиглах асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын санал болгосноор Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн шийдвэрлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.8 хувиар дэмжигдлээ.

Шинэчилсэн найруулгын төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. 7 дугаар зүйл дээр ажлын хэсэг нэг саналтай төслийн.

Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “нисэхийн” гэсний дараа “хяналтын” гэж нэмж, мөн зүйлийн 7.1.2 дахь заалтын “шинжээч /байцаагч/-ийг томилох” гэснийг “шинжээчийг томилох, чөлөөлөх” гэж, мөн зүйлийн 7.1.5 дахь заалтын “цагийн хөлсний үнэлгээний тусгай норм, зэрэг, зэрэглэлийг” гэснийг “цагийн үнэлгээ, зэрэг, зэрэглэлийн нэмэгдлийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.3, 7.1.4 дэх заалт нэмэх:

“7.1.3.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комиссын дүрмийг батлах;

7.1.4.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинэчлэн шалгах комиссыг томилох;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 58.8 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг 8 дугаар зүйл дээр нэг саналтай төслийн.

6.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтын “мэргэжлийн үнэмлэх,” гэсний дараа “нислэгт тэнцэх чадварын” гэж нэмж, мөн зүйлийн 8.2.3 дахь заалтын “хөтлөх”

гэснийг “бүрдүүлэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 8.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.2.5.улсын нисэхийн аэродромыг бүртгэх, гэрчилгээжүүлэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.8 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбоотойгоор саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг нэг саналтай. 7.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалтын “хуулийн” гэсний дараа “8.2 дугаар зүйлийн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. 52.9 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбоотойгоор саналтай гишүүд байна уу? Энхтүвшин гишүүн асуулттай байна. Санал.

**Д.Энхтүвшин:** Энэ зарчмын зөрүүтэй санал гаргасан байгаа хуулийн төслийн 10.4 дээр. Томьёолол нь болохоор улсын агаарын хөлгийн засвар, техникийн үйлчилгээ болон нисэх баг, инженер, техникийн бүрэлдэхүүний сургалтын тодорхой хэсгийг эдийн засгийн үр ашиг, чанар, аюулгүй байдлыг харгалзан дотоодын болон гадаадын гэрчилгээжсэн хувийн хэвшлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Энэ тохиолдолд тавигдах шаардлага, журмыг улсын нисэхийн багц дүрмээр тогтооно гээд ийм саналын зөрүүтэй томьёолол оруулсан байгаа.

Тэгэхээр энэ гол зорилго нь болохоор хувийн хэвшлээр энэ засвар үйлчилгээг, энэ сургалт дээр зарим нэг чиг үүргүүдийг бүгдийг нь улс өөрөө хийхгүй байх ийм бодит нөхцөл байдал дээр бол ийм хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх тодорхой хэсгийг нь, нууцлалтай холбоотой асуудлууд байдаг учраас тэрийг нь тусдаа журмаар тодорхойлохоор энэ орон зайг нээж өгөхгүй бол үйлчилгээ үзүүлэх, засвар үйлчилгээ ч гэдэг юм уу асуудал орохоор зөвхөн улс өөрсдөө яана гээд энд агаарын тээврийн бүрэлдэхүүн чинь үйлчилгээндээ гарч чадахгүй иймэрхүү нөхцөл байдал хуулиар хязгаарлагдсан нөхцөл байдал үүсэж магадгүй учраас энэ орон зайг нээх үүднээс ийм саналын томьёолол 10.4 гэсэн зүйл заалт дээр нэмэх саналтай байна.

**Г.Тэмүүлэн:** Энхтүвшин гишүүний саналыг, ажлын хэсгийн ахлагч Анар.

**Ч.Анар:** Энхтүвшин гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжиж байгаа. Яагаад гэхээр одоогийн байдлаар БХЯ дээр бодит байдал дээр үйл ажиллагааны зардлыг хэмнэх, төр, хувийн хэвшлийн түншлэлээр улсын нислэгийн үйл ажиллагааг хувийн хэвшилтэй хамтран засвар үйлчилгээ, ашиглалтыг хариуцан ажиллаж байгаа. Тэгэхээр энэ хууль дээр энэ заалт орхигдсоныг та нэмж өгч байна, энийг дэмжиж байна.

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсэг дэмжиж байгаа юм байна. Тулга гишүүн асуулт байна. Тулга гишүүн асуулт асууя.

**Б.Тулга:** 10.2 дээр дадлагажууртай гээд дадлагажуур гэж юу байдаг юм бэ? Тэрийг нэг тайлбарлаж өгөөч? Энэ үсгийн алдаа юу, техникийн алдаа юу дадлагажууртай байна гэсэн байх юм хууль дээр чинь.

**Г.Тэмүүлэн:** ЗХЖШ-ын дарга Ганбямба дарга асуултад хариулья. Индрийн микрофон.

**С.Ганбямба:** Тулга гишүүний асуултад хариулъя. Энэ нөгөө симулятор, тренажёр гэдгийг Монголчлоод дадлагажуур гэж байгаа юм. Тэгээд битүү бүхээгийн тренажёр дээр дадлага хийх хэрэгцээ шаардлага гардаг. Тэгэхээр тэрийгээ Монголчлоод дадлагажуур гэдгээр оруулсан байгаа. Энэ нэр томьёо маань угаасаа дүрэм дээр байгаа юм байна. Иргэний нисэхийн дүрэм журам дээр байгаа юм байна.

**Г.Тэмүүлэн:** Энэ нэр томьёо нь угаасаа дүрэм дээр бас байгаа юм Иргэний нисэхийн дүрэм журам дээр бол байгаа юм байна. Энхтүвшин гишүүний саналын томьёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүн нэг санал гаргасан.

“10.4.улсын агаарын хөлгийн засвар, техникийн үйлчилгээ болон нисэх баг, инженер, техникийн бүрэлдэхүүний сургалтын тодорхой хэсгийг эдийн засгийн үр ашиг, чанар, аюулгүй байдлыг харгалзан дотоодын болон гадаадын гэрчилгээжсэн хувийн хэвшлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Энэ тохиолдолд тавигдах шаардлага, журмыг улсын нисэхийн багц дүрмээр тогтооно.” Гэсэн байна. Дэмжье гэдгээр санал хураалтыг явуулъя. Санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ.

Ажлын хэсэг 3 саналтай байгаа юм байна. Ажлын хэсэг 10 дугаар зүйл дээр. 8.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.1.1, 10.1.2 дахь заалт болгох:

“10.1.1.нислэгийн үйл ажиллагааг хариуцсан нэгжтэй байх;

10.1.2 нь шалгагч зэрэглэлтэй нисгэгч, инженерийг томилох, чөлөөлөх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн дараагийн санал. Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.1.3 дахь заалт болгох:

“10.1.3.Улсын нисэхийн багц дүрэм болон агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан дүрэм, зааврын дагуу нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын “улсын агаарын хөлөг,” гэсний өмнө “энэ хуулийн 4.1.3-т зааснаас бусад” гэж нэмж, мөн зүйлийн 10.1.4 дэх заалтын “тасралтгүй” гэснийг, мөн зүйлийн 10.1.5 дахь заалтын “заавал” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.6 дахь заалт нэмэх:

“10.1.6.энэ хуулийн 14.1.2, 14.1.3, 14.1.4-т заасан нислэг үйлдэхэд зорчигчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн даатгалыг гэрээ байгуулагч тал хариуцах.” Санал гаргасан ажлын хэсэг. 64.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбоотой саналтай гишүүд байна уу? Асуулт байна. Ганбат гишүүний микрофоныг өгье. 11 дүгээр зүйл. Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** 11.1.11-д энэ хэрэгслийг бүртгэх гэж байна. Тэгээд хэрэгсэл, түүний удирдлагын системийг бүртгэх гэж өөрчлөх юм байна. Тэгээд сүүлийн үед ийм болсон. Энэ нисгэгчгүй нисэх төхөөрөмж, дрон /drone/ гээд энийг бараг цэргийн зориулалтаар ашиглаж болдог болчихсон, маш амархан өөрчлөөд. Хуучин 1, 2

жилийн өмнө энэ манай хөрш орнууд Бээжин хот энэ тэрд чөлөөтэй зардаг байсан. Сүүлийн хэдхэн сарын мэдээллээр тэр бүх юмнуудыг, төхөөрөмжийг бүгдийг нь хураагаад авчихсан байгаа. Дрон зардаг дэлгүүр ажиллахаа байчихсан, бүх дронуудыг бүртгэлтэй болчихсон байгаа. Энд энэ юм орж байна уу, орохгүй байна уу, энэ талаар тодруулъя? Бас мэдээлэл цуглуулахад ч гэсэн ашиглаж эхэлж байна шүү энэ төхөөрөмжийг.

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсгийн ахлагч хариулъя. Анар гишүүн.

**Ч.Анар:** Ганбат гишүүн та яг энэ санал, таны энэ саналыг тусгаж энэ дээр оруулсан байгаа. Зөвхөн улсын агаарын хөлгийг буюу агаарын хөлгийг бүртгэлжүүлж гэрчилгээжүүлэх байсан бол орчин үед нөгөө нисгэгчгүй нисэх хэрэгсэл, бүр тэр ч байтугай нисгэгчтэй нисэх хэрэгсэл ч гэсэн нөгөө удирдлагын систем нь алсын зайн удирдлагын системтэй болсон байгаа. Тэрийг ч гэсэн үндэсний аюулгүй байдал болон аюулгүйн байдлын зүгээс бүртгэлжүүлэх, хянах шаардлагатай болсон учраас энэ заалтыг нэмж оруулсан байгаа. Тэгэхээр энэ зүйл, заалт яг таны санаа зовж байгаагийн дагуу энэ заалт нэмэгдэж орсон байгаа гэсэн үг.

**Г.Тэмүүлэн:** Ганбат гишүүн нэмж тодруулъя.

**Д.Ганбат:** Энэ хэрэгслүүдээ тэгээд иргэд маань өөрсдөө бүртгүүлэх үүрэгтэй юу, эсвэл зарж байгаа байгууллагууд нь бүртгүүлэх ёстой юу, энэ талаараа тусгасан уу?

**Г.Тэмүүлэн:** Анар гишүүн асуултад хариулъя.

**Ч.Анар:** Энэ улсын нисэхийн тухай хууль дээр энэ ерөөсөө түрүүн бас Тулга гишүүн асууж байсан. Улсын агаарын хөлөг гэдэг маань өөрөө төрийн цэргийн байгууллага болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын л агаарын хөлөг буюу нисдэг тэргүүд орж байгаа. Тэрнээс иргэний болон иргэдийн гар дээр байгаа нисгэгчгүй нисэх хэрэгсэл болон агаарын хөлгүүд Иргэний нисэхийн тухай хуулиар зохицуулагдана. Иргэдийн гар дээр байгаа бага оврын дронууд бол Дроны тухай хуулиар Цахим яам дээр боловсрогдож байгаа, тэрүүгээр зохицуулагдана. Үүн дээр бол зөвхөн том оврын төрийн цэргийн байгууллагын болон тусгай чиг үүргийн улсын агаарын хөлөг болон иргэний агаарын хөлгүүдэд саад бэрхшээл учруулж болохуйцаар тусгай дронуудыг нууцын журмаар бүртгүүлж оруулж ирж байгаа юм. Тэр харилцаа л зохицуулалт нь. Иргэдийн гар дээр байгаа жижиг оврын дронууд бол улсын агаарын хөлгийн зохицуулалтдаа орохгүй гэсэн үг.

**Г.Тэмүүлэн:** Боллоо. 11 дүгээр зүйлтэй холбоотойгоор асуулт асууж, хариулт авлаа. Ажлын хэсэг нэг саналтай байгаа.

11.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалтын “бүртгэлийн гэрчилгээ нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах,” гэснийг “хасах, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, хүчингүй болгох;” гэж, мөн зүйлийн 11.1.11 дэх заалтын “хэрэгслийг бүртгэх,” гэснийг “хэрэгсэл, түүний удирдлагын системийг бүртгэх,” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт, дэмжье гэдгээр. Баярлалаа. 64.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлтэй холбоотой асуулттай гишүүд байна уу? Алга байна. 12 дугаар зүйл дээр ажлын хэсэг 1 санал, 2, 3 саналтай байна.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “заасны дагуу” гэсний дараа “улсын агаарын хөлгийн бүртгэл” гэж, мөн хэсгийн “бүртгүүлээгүй,” гэсний дараа “нислэгт тэнцэх чадварын гэрчилгээгүй улсын” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 12.3 дахь хэсэг болгох:

“12.3 Улсын агаарын хөлөг нь нислэгийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангасан нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй байна.” гэж ажлын хэсэг, санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 64.7 хувиар дэмжигдлээ.

13. Төслийн 12 дугаар зүйлийн “Улсын агаарын хөлгийг бүртгэх, бүртгэлээс хасах, нислэгт тэнцэх чадварыг тодорхойлох, гэрчилгээ олгох, сунгах, цуцлах үйл ажиллагааг Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулна.” гэсэн 12.6 дахь хэсэг, мөн зүйлийн “Энэ хууль болон Улсын нисэхийн багц дүрмийг зөрчсөн тохиолдолд агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно.” гэсэн 12.7 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт, дэмжье гэдгээр санал хураалт. Гишүүдэд баярлалаа 70.6 хувиар дэмжигдлээ.

14. Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.6 дахь хэсэг нэмэх:

“12.6. Энэ хуулийн 10.1.5-д заасан даатгалыг улсын төсвийн санхүүжилтээр шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Тэгье. Чинбаатарын Анар гишүүн дугаарлалт дээр нь Анарт гишүүн

**Ч.Анар:** Энэ Жанжин штабаас дахиад нэмээд тодруулах хэрэгтэй байх. Улсын нисэхийн агаарын хөлгүүдийг захиалгат нислэг болгон нь онцгой үүргийн нислэг гүйцэтгэх үед ерөөсөө даатгуулдаггүй байсан. Энэ нь улсын төсөвт суудаггүй. Тэгэхээр өнөөдөр хүртэл бол иймэрхүү эрсдэл нь агаарын хөлөг цаг агаарын, нисгэгчийн ур чадварын улмаас осолдох тохиолдолд даатгалын харилцааг зохицуулагддаггүй. Хууль дээрээ заагдаагүй байсан учраас улсын төсөвт суулгадаггүй байсан учраас энэ нөгөө нисдэг тэрэг гэмтэх, агаарын хөлөг гэмтэх тохиолдолд том үнийн дүнтэй хохирол учирдаг байсныг энэ чинь хууль дээр тусгаж өгч байгаа юм. Тэгэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүд маань энэ заалтыг та хэд маань ач холбогдлыг нь ойлгоод дараагийн удаа төсөв дээр анхаарч өгөхөд нь дэмжиж өгөөрэй гэж хүсье.

**Г.Тэмүүлэн:** Ойлголоо. Саяын энэ 13, 14 дэх саналыг та хэд маань ингээрэй. Энэ нэг нь хасах, хасах гээд дараачийнх нь нэмэх гэдгээр орж ирж байгаа юм байна. Тэгэхээр ерөөсөө өөрчлөн найруулах гэдгээр орчихвол 2 санал руу хоёулаа нийлээд нэг санал болоод орчих боломжтой юм байна шүү. Тэгээд 12.6 дахь энэ саналын томъёоллыг нэгтгээд ингээд хийчихье. Энийгээ ажлын хэсэг анхаараарай.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлтэй холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг нэг саналтай.

Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.3.Агаарын хөлгийн дарга нислэгийн аюулгүй байдалд аюул тулгарсан тохиолдолд улсын агаарын хөлөгт байгаа зорчигчдын амь насыг аврах зорилгоор нислэгийн төлөвлөгөө болон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн өгснөөс өөр шийдвэр гаргах эрхтэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт, дэмжье гэдгээр санал хураалт. Санал хураалт 64.7 хувиар дэмжигдлээ.

16.Төслийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийн “үүрэг гүйцэтгэгч” гэснийг “ажиллуулж” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.7.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрээгээр ажиллах гадаад улсын иргэн, хуулийн этгээдэд улсын агаарын хөдөлгөөний нисэх, техник үйлчилгээ хийх эрхийг дараах шаардлагыг үндэслэн олгоно:

13.7.1.мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ нь хүлээн зөвшөөрөгдсөн байх;

13.7.2.үндэсний аюулгүй байдал, эрсдэлийн үнэлгээ болон шалгалт хийгдсэн байх;

13.7.3.улсын агаарын хөлөг эзэмшигч байгууллагатай төрийн нууцын хууль тогтоомжийн дагуу нууцын баталгаа, нууц хадгалах гэрээ байгуулсан байх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбоотой асуулттай гишүүд байна уу? Тулга гишүүн.

**Б.Тулга:** 14 дүгээр зүйл дээр тусгай үүргийн, онцгой үүргийн нислэг гээд орж ирж байх шиг байна л даа. Тэгэхээр энэ тусгай үүргийн, онцгой үүргийн нислэг өөрөө улсын нөгөө энэ хуулиар зохицуулж байгаа нисэх төхөөрөмжөөр биш, хувийн төхөөрөмжөөр хийгдвэл аль хууль дээрээ зохицуулж байгаа вэ? Энэ хуулиар чинь байлдааны гэдэг юм уу, цэргийн зориулалттай юмаар, техник хэрэгслээр, онгоцоор нисэж байгаа зохицуулалтыг хийгээд байна шүү дээ. Гэтэл яг энэ чиглэлийн нөгөө тусгай үүргийн, онцгой үүргийн гэсэн энэ ангилал ороод ирээд байна шүү дээ. Онцгой үүргийн нислэг, тусгай үүргийн нислэг гээд бодвол Ерөнхийлөгчийн нислэг энгийнээр явах нь байна шүү дээ. Тэгэхээр энэ энгийнээрээ нөгөө Иргэний агаарын тээврийн хууль дээрээ байдаг юм уу, энэ хуулиараа зохицуулагдах уу, альгүйгээр зохицуулагддаг юм бэ асуулт?

**Г.Тэмүүлэн:** Асуултад хариульъя ЗХЖШ-ын дарга С.Ганбямба генерал. Индрийн микрофон.

**С.Ганбямба:** Онцгой үүргийн нислэг, тусгай үүргийн нислэг энэ хуулиар зохицуулагдана. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд улсын агаарын хөлөг ба иргэний агаарын хөлгөөр алинаар нь ч ниссэн энэ бол онцгой үүргийн нислэг байна. Ингэж зохицуулагдаж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Анар гишүүн нэмж хариулах уу? Ажлын хэсгийн дарга.

**Ч.Анар:** Тулга гишүүний асуулт энэ Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 24.5 дахь хэсэгт нөгөө иргэний болон улсын нисэхийн байгууллага нь

хамгаалуулагчийн хөлөглөн явах агаарын хөлгийн техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана гэж заачихсан байгаа. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, тэрэн дээрээ яг энэ 14.6-г нийцүүлээд гаргасан. Тийм. Тэгэхээр Иргэний нисэхийн тухай хууль дээр бас байгаа гэсэн үг.

**Г.Тэмүүлэн:** 14 дүгээр зүйл дээр ажлын хэсэг нэг саналтай, Энхтүвшин гишүүн нэг саналтай байна. Энхтүвшин гишүүний микрофоныг өгье. Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Энэ 14.3 дээр нэг санал байгаа. Энэ одоогийн хуулийн төслөөр болохоор улсын агаарын хөлгөөр захиалгат нислэг үйлдэх бол Иргэний нисэхийн тухай хууль, дүрмийн холбогдох зохицуулалтыг баримтална гээд. Одоогийн хууль дээр болохоор энэ хуулийг баримтална гэж байсныг нь холбогдох гэхээр хамрагдах хүрээг нь хумьсан юм шиг ийм ойлголт байгаа учраас энэ холбогдох гэдгийг нь хасах ийм санал байгаад байгаа юм энэ дээр.

**Г.Тэмүүлэн:** Тэгэхээр Иргэний нисэхийн тухай хууль, дүрмийн зохицуулалтыг баримтална гэж болох юм байна тийм ээ?

**Д.Энхтүвшин:** Иргэний нисэхийн тухай хууль, дүрмийн зохицуулалтыг баримтална гээд, холбогдох гэдэг л үгийг нь.

**Г.Тэмүүлэн:** Холбогдох гэдэг үгийг нь л авах юм байна шүү дээ, найруулгын маягтай засвар юм биш үү? Батлут сайд.

**Д.Батлут:** Энэ холбогдох дүрмийн заалтыг, заалтаар зохицуулна гэж байх нь зөв байх. Яг үндсэндээ Иргэний нисэхийн тухай хуультай холбоотой, холбогдох дүрэмтэй холбоотой дүрмийн зохицуулалт бүрэн хэмжээгээр ашиглах боломжгүй Улсын нисэхийн тухай хууль дээр, улсын нисэх дээр. Тийм учраас холбогдох тодорхой зохицуулалтуудыг л бид ашиглах боломжтой болно гэж харж байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Тэгвэл саналаа татлаа. Энхтүвшин микрофонд хэлье.

**Д.Энхтүвшин:** Тайлбарыг сонсож ойлголоо. Тэгээд би саналаа татчихъя.

**Г.Тэмүүлэн:** Ойлголоо. Энхтүвшин гишүүн саналаа татлаа. Ажлын хэсгийн нэг санал байгаа.

Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.6 дахь хэсэг нэмэх:

“14.6.Энэ хуулийн 14.1.2-т заасан нислэгийн аюулгүйн хамгаалалтыг хангах асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хамтарсан журмаар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. 70.6 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлтэй холбоотой саналтай гишүүд, асуулттай гишүүд байна уу? Алга байна. 16 дугаар зүйлтэй холбоотой асуулттай гишүүд байна уу? Алга байна. Ажлын хэсэг саналтай байна 16 дээр. 16 дээр.

Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “аэродром ашиглах үйл ажиллагаа, түүнд тавигдах шаардлагыг” гэснийг “ашиглах, түүний бэлэн байдлыг”

гэж өөрчилж, мөн зүйлийн “Цэргийн зориулалтын нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, татан буулгах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын санал болгосноор Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн Засгийн газар шийдвэрлэнэ гэсэн.” 16.2 дахь хэсэг, мөн зүйлийн “Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын нисэхийн аэродром байгуулах, түүний бэлэн байдал, түүнд тавигдах шаардлагыг тогтоох тухай саналыг боловсруулж Засгийн газраар шийдвэрлүүлнэ.” гэсэн 16.3 дахь хэсэг, мөн зүйлийн “Улсын нисэхийн аэродромын бүртгэлийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхэлнэ.” гэсэн 16.5 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт, дэмжье гэдэг санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлтэй холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 18 дугаар зүйлтэй холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. 18 дээр ажлын хэсэг 3 саналтай байна.

Төслийн 18 дугаар зүйлийн “Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналтыг энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллага хэрэгжүүлнэ.” гэсэн 18.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйлийн 18.3 дахь хэсгийг 18.2 дахь хэсэг болгох. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн дараагийн санал, Төслийн 18 дугаар зүйлийн 18.3.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.2.1, 18.2.2 дахь заалт болгох:

“18.2.1 эрх бүхий албан тушаалтнаас олгосон албаны үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэх;

18.2.2.албан үүрэг гүйцэтгэхтэй холбоотой албан шаардлага, зөвлөмж, дүгнэлт гаргах, хэвлэмэл хуудас хэрэглэх;” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ.

21.Төслийн 18 дугаар зүйлийн “дээрх заалтын дагуу хийгдэх үйлдэл, байцаагчийн үүрэг даалгаврыг гүйцэтгэх хугацаа болон бусад нэмэлт зохицуулалтыг Улсын нисэхийн багц дүрмээр нарийвчлан зохицуулна.” гэсэн 18.3.6 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ.

22.Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.4.4 дэх хэсэг нэмэх:

“18.4.Цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгслийг энэ хуулийн 11.1.11-д заасан шаардлага хангаагүй тохиолдолд ашиглахыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ.

19 дүгээр зүйлтэй холбоотой асуулттай гишүүд байна уу? Алга байна. Саналтай гишүүд алга байна.

Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.1.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах чиглэлээр зорчигчийн бие, ачаа тээшинд агаарын хөлгийг эзэмшигч болон мэргэжлийн байгууллага холбогдох дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг хийнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ. Баярлалаа.

24.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.4 дэх хэсэг нэмэх:

“19.4.Улсын нисэхийн үйл ажиллагаанд ашиглагдах мэдээллийн технологи, навигаци, хяналт, нислэгийн удирдлагын систем нь кибер аюулгүй байдлын шаардлагад нийцсэн байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.7 хувиар дэмжигдсэн байна.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлтэй холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. Одоо 5 байна.

Төслийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “Эрэн хайх” гэсний өмнө “Улсын агаарын хөлгийг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлтэй холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “эрлийн ажлыг зогсоох шийдвэрийг уг агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын саналыг үндэслэн” гэснийг “мэргэжлийн комиссын саналыг үндэслэн эрлийн ажлыг зогсоох шийдвэрийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлтэй холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. Тулга гишүүн.

**Б.Тулга:** 22.2 дээр чинь энэ төсөл дээрээ байгаагаар хуулийн 7.1.2-т заасны дагуу томилогдсон ерөнхий шинжээч, нисгэгч, инженер эсхүл шалган шалгагч чиглэлээр мэргэшсэн нисэхийн бусад мэргэжилтэй, хараат бус, бие даасан гээд байгаа юм. Батлан хамгаалахын сайд томилчхож байгаа юм. Батлан хамгаалахын сайд 23 дээрээ дахиад энэ шинжээчийн ажиллах дүрмийг баталчхаж байгаа. Ингээд нөгөө хараат бус байна гэдэг чинь энэ дээр яаж хангагдаад байгаа юм бол?

Олон улсын жишгээр бол ямар ч тохиолдолд осол, аваар болсон бол энийг шинжлэн судлах нь бол тухайн байгууллагаас үл хамаарсан ийм шалгалт юуны баг ордог шүү дээ. Энэ дээр ямар зарчим баримталсан юм бол? Энэ дээр нөгөө хараат бус гэдэг чинь хангагдахгүй байгаа юм шиг л харагдаад байх юм.

**Г.Тэмүүлэн:** Батлут сайд.

**Д.Батлут:** 7-н 22.3 дээр тодорхой зохицуулалтууд байгаа. Хуулийн төслийн 7.1.2-т улсын нисэхийн нислэг, техникийн осол, зөрчлийг шинжлэх, шалгах, ерөнхий шинжээчийг томилох, чөлөөлөх гэсэн зохицуулалтын дагуу нислэг, техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээч нь хараат бус, нислэгийн мэргэжлийн энэ чиглэлээр мэргэшсэн байх шаардлагын үүднээс уг зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгасан байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл, аливаа осол, зөрчил үүссэн

тохиолдолд түүнийг шинжлэн шалгах, эцсийн дүгнэлтийг гаргах субъект нь тухайн асуудлаар мэргэшсэн, үнэн зөв дүгнэлт гаргах чадвар эзэмшсэн байх шаардлагыг зохицуулж тусгасан байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй.

**Г.Тэмүүлэн:** Ойлголоо. 27.Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.2, 22.4, 22.5, 22.6, 22.7 дахь хэсгийг нэмэх:

“22.2.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь осол, зөрчлийг дахин давтагдахаас урьдчилан сэргийлнэ.

22.4.Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналт, осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцох албан тушаалтан нь агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын агаарын хөлгийг худалдан авахтай холбоотой ажиллагаанд шууд болон шууд бус ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол худалдан авах ажиллагаанд оролцохоос татгалзана.

22.5.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцох ерөнхий шинжээч, комиссын гишүүд нь улсын агаарын хөлгийг үйлдвэрлэгч болон засвар, техникийн ажиллагааг хариуцах байгууллагатай ашиг сонирхлын зөрчилгүй эсэх талаарх эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.

22.6.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны талаарх баримт мэдээллийг устгах, өөрчлөх, нуун дарагдуулах, задруулахыг хориглоно.

22.7.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны нууцад хамаарахаас бусад мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.” Санал хураалт. Санал хураалт 64.7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 23 дугаар зүйлтэй холбоотой асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. 23 дугаар зүйл ажлын хэсэг саналтай.

Төслийн 23 дугаар зүйлийн гарчгийн “бүрэн эрх, чиг үүрэг” гэснийг “эрх, үүрэг” гэж, мөн зүйлийн 23.1 дэх хэсгийн “бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэснийг “эрхтэй” гэж, мөн хэсгийн 23.1.2 дахь заалтын “хүн” гэснийг “албан тушаалтан” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 23.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.1.1.албан үүргээ гүйцэтгэхдээ улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага болон шаардлагатай бусад газар саадгүй нэвтрэх;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ.

29.Төслийн 23 дугаар зүйлийн 23.2.3 дахь заалтын “дүрмийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах” гэснийг “дүрмийн төслийг боловсруулах” гэж өөрчилж, мөн зүйлийн улсын агаарын хөлгийн нислэг-техникийн осол, зөрчлийн шалтгааныг үнэн зөв тогтоох, шаардлагатай мэдээ, судалгаа, бусад баримт бичгийг холбогдох этгээдээс шаардан гаргуулж авах.” гэсэн 23.1.6 дахь хэсэг, мөн зүйлийн “улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс томилуулах тухай саналаа батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх;” гэсэн 23.2.4 дэх заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ.

30 дахь санал. 24 дүгээр зүйлтэй холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. Төслийн 24 дүгээр зүйлийн гарчгийн “комисс, түүний бүрэн эрх” гэснийг “комиссын чиг үүрэг” гэж, мөн зүйлийн 24.1 дэх хэсгийн “түүний бүрэн эрх” гэснийг “дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж, мөн зүйлийн 24.1.1 дэх заалтын “зүйлст хяналт хяналтаа тогтоох” гэснийг “зүйлсийг хяналтад авах” гэж, мөн зүйлийн 24.1.5 дахь заалтын “болсон” гэснийг “улсын” гэж, мөн зүйлийн 24.3 дахь хэсгийн “уг осол зөрчлөөс урьдчилан сэргийлнэ арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ” гэснийг “осол, зөрчил гаргахгүй байх талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлнэ.” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Найруулгын одоо 2 санал байгаа юм байна. Тэгээд дуусаж байна. Дагах хууль дээр байгаа юм уу, хаана байна?

Найруулгын санал. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “зохицуулалт,” гэсний дараа, 8 дугаар зүйлийн 8.2.6 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.2, 13.4 дэх хэсгийн “агаарын” гэсний өмнө, 21 дүгээр зүйлийн гарчгийн “нэрвэгдсэн” гэсний дараа “улсын” гэж тус тус нэмж, төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын “цогцолбор” гэснийг “цогц” гэж өөрчилж, төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “гарсан” гэснийг хасах. Санал гаргасан. Ажлын хэсэг санал хураалт. 52.9 хувиар дэмжигдлээ.

Дагасан хууль дээр нэг санал байна. Хоёр.Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн “... 9.1.1, 9.1.2-т...” гэснийг “9.1.2, 9.1.6-д” гэж өөрчлөх: Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ.

Найруулгын санал байна. 3 найруулгын санал.

1.Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.7 хувиар дэмжигдлээ. Санал хураалтууд явагдаж дууссан.

БХЯ-ны удирдлагууд байгаа дээр сайд, дэд сайд, ТНБД, ЗХЖШ-ын дарга нар байна. Энэ ажлын хэсэг мэдээж сайн ажиллаад, энэ хуулийн төслүүдийг шуурхай оруулж ирээд ингээд УИХ-аар хэлэлцэхэд бэлэн боллоо. Байнгын хороогоор дэмжлээ. Байнгын хорооноос Зэвсэгт хүчин болоод Жанжин штабтай холбоотой, БХЯ-тай холбоотой бүх асуудлууд дээр бүх талын бодлогыг дэмжиж үзүүлж ажиллаж байгаа шүү. Бид сая сүүлд өнгөрсөн сар 5-р сард Зэвсэгт хүчин, Жанжин штаб дээр очиж ажилласан. Жанжин штаб болоод дэд сайдад чиг үүрэг, даалгавар өгөөд, Байнгын хорооны шинжээч, референтүүдтэй хамтраад тогтоолын төслийг оруулж ир гэсэн чиглэл өгсөн байгаа. Энэ тогтоолын төслийг 6-р сардаа оруулаад Байнгын хороогоор баталъя. Бодлогын болоод үйл ажиллагаа дээр дэмжлэг үзүүлж байгаа.

Нэг зүйлийг би анхааруулж хэлэхгүй бол болохгүй. Сая Зэвсэгт хүчин дээр болсон, цэргийн анги, нэгтгэл дээр цэргийн амь нас эрсэдсэн асуудал гарсан. Ийм зүйл байх ёсгүй. Зэвсэгт хүчин дээр болоод цэргийн анги, нэгтгэлд дүрмийн бус харьцаа буюу ёс зүйгүй харьцаанууд, дарамт, шахалтууд цэрэг, албан хаагч нар дээр байх ёсгүй шүү. Тэгэхээр энэ асуудлууд дээр онцгой ажил хариуцсан дарга анхаарч ажилла. Тэрнээс бид холбогдох Байнгын хороо, УИХ-аас та бүхний төсөв, санхүүжилтийг байнгын дэмжиж ирсэн. Сүүлийн 3-аас 4 жилийн хугацаанд 200-аас 300 тэрбум байсан үйл ажиллагааны зардлуудыг 700-аас 800 тэрбум төгрөг болгосон шүү.

Тэгэхээр би онцгойлж хэлэх гээд байгаа нь Батлан хамгаалахын дэд сайд Баасандамба та төрийн тусгай үүргийн байгууллагад тодорхой хугацаанд ажилласан хүн байгаа. Тэгэхээр төрд хүндэтгэлтэй харьцаарай, бид бүхий л талаар бодлогоор дэмжиж ажиллана. Тэгэхээр та бүхэн дотооддоо, үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийгээд, дүгнэлт гаргаад, дотоод хяналтынхаа тогтолцоог шинэчлэх гэдэг юм уу, дээрээс нь энэ хариуцлагын тогтолцоогоо чангатгах асуудлууд дээр анхаарч ажиллаарай. Яг энэ цаашид юу гэдэг юм, ийм харамсалтай зүйлүүд, цэргийн амь нас эрсэдсэн зүйлүүд Зэвсэгт хүчин дээр гаргахгүй байх талаар манай БХЯ, Зэвсэгт хүчний Жанжин штаб бүхий л шаардлагатай арга хэмжээнүүдийг авах, тогтолцооны шинэчлэлүүдийг хийх ёстой шүү гэдгийг би хатуу анхааруулж хэлж байна.

Санал хураалт, санал хураалтыг явуулж дууслаа. Чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг томилъё, ажлын хэсгийн дарга Анар гишүүнээр томилъё. Анар гишүүн, ажлын хэсгийн дарга Байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэнэ.

18.17 цаг

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан байна. Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Ажлын хэсэг, Байнгын хорооны гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийнхэндээ баярлалаа, идэвхтэй шуурхай ажилласан байна. Батлан хамгаалах яамны хамт олон, удирдлагуудад баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА